

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-9
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	10-45
<hr/>	
<i>1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	10-12
<i>2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	12-31
<i>3. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	31-45

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 11 дүгээр сарын 07-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 02 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Б.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Л.Мөнхбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах **санал хураалт явуулья.**

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хууль, тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу,

Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн дарга В.Хосбаяр, мөн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, мөн газрын шинжээч Т.Нарантунгалаг, мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Д.Цогтбаатар, Д.Ганбат, С.Бямбацогт нарын тавьсан асуултад Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн дарга В.Хосбаяр нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 4, 5, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ш.Адъяаа, Г.Амартүвшин, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Б.Энх-Амгалан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “12.1 дүгээр зүйлийн 5 дахь” гэснийг “12.1 дүгээр зүйлийн 4 дэх” гэж, мөн зүйлийн 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “22 дугаар бүлэгт” гэснийг “22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь

хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 3 дахь заалтын 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “10.1 дүгээр зүйлийн 2, 3” гэснийг “10.1 дүгээр зүйлийн 3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ““мэргэжлийн үйл ажиллагаа явуулах,” гэсний дараа “тээврийн хэрэгслийг жолоодох” гэж, мөн хэсгийн “нийтийн албанд ажиллах” гэсний дараа “, тээврийн хэрэгслийг жолоодох” гэснийг ““тохиолдолд” гэсний дараа “тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс арван хоёр жил хүртэл, эсхүл” гэж өөрчилж, мөн зүйлийн “гэж, 12.3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын “арван зургаан насанд” гэсний дараа “хүрсэн арван найман насанд” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасаж, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хорин” гэснийг “хорин таван” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.10 дугаар зүйл.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих

1.Тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.согтуурсан, мансуурсан үедээ;

2.2.тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй хүн;

2.3.хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулж үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс дээш таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс дээш найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

4.1.согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн;

4.2.энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг найман жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Тээврийн хэрэгслийг жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгслийг жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “согтуурсан” гэж шалгаж, тогтоох ажиллагааны үр дүнд шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0.20, түүнээс дээш промиль (%), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0.5, түүнээс дээш промиль (%) илэрснийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгслийн жолооч” гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа тээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй, эсхүл эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүнийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэдэгт согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүнийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгсэл” гэж механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 1

Бүгд: 13

92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн ““10.1 дүгээр зүйлийн Тайлбарын “арван дөрвөн” гэснийг “арван зургаан” гэж, “12.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэснийг, мөн зүйлийн “2.1 дэх заалтын “арван дөрвөөс” гэснийг “арван зургаагаас” гэж, мөн зүйлийн”” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ц.Сэргэлэн, Д.Ганбат, Д.Цогтбаатар, Ц.Мөнх-Оргил нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Сандаг-Очир нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3, 4, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“8.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, шинээр авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт, хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 8
Бүгд: 14
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх үндэслэл нь энэ хуулийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.18, 5.20, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.17, 6.18, 6.20, 6.22, 6.23, 6.26, 6.27 дугаар зүйл, Долдугаар бүлэг, 8.1, 8.6, 8.7, 8.8, 8.9, 9.7, 10.3, 10.7, 10.15, 10.25 дугаар зүйл, Арван нэгдүгээр бүлэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.6, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13 дугаар зүйл, Арван тав, Арван зургадугаар бүлэг, 17.1 дүгээр зүйлд тус тус заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон шилжүүлэх.

“3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“5.Жолооч:

5.1.согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.3.согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж, дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 3

Бүгд: 13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн ““1.2, 1.3, 1.4 дэх заалтын дугаарыг “1.3, 1.4, 1.5;” гэснийг “1.2., 1.3. дахь заалтын дугаарыг “1.3., 1.4.”” гэж өөрчилж, мөн зүйлийн “3.5-3.8 дугаар зүйлийн дугаарыг “3.7-3.10” гэж,” гэснийг “14.7 дугаар” гэсний өмнө шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “**агуулга бүхий зүйл, хэсэг**” гэснийг “агуулгатай дараах зүйл, хэсэг” гэж өөрчилж, 3 дахь заалтын 3 дахь хэсгийн “саналаа” гэсний дараа “оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил гаргасан харьяаллын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 2

Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 41.2 дахь хэсгийн “10.1 дүгээр зүйлийн” гэсний дараах “2,” гэснийг хасаж, мөн зүйлийн 12.1 дүгээр зүйлийн “5 дахь” гэснийг “4 дэх” гэж, 4 дүгээр зүйлийн “2024 оны ... дүгээр/дугаар сарын ...-ны” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо, Хууль зүйн, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъяанхүү, мөн хэлтсийн шинжээч М.Цолмон, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга Ч.Оюунцэцэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Төгөлдөр, ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Н.Өлзийхутаг, Олон Улсын Улаанбаатар их сургуулийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал О.Амарсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Ц.Мөнхцэцэг, Н.Учрал, Ш.Адьяа, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо, Олон Улсын Улаанбаатар их сургуулийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал О.Амарсанаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан 18 цаг 26 минутаас 18 цаг 36 минутад хуралдааныг даргалав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 52 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 18 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 16 цаг 02 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Ингээд Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ширнэнбандийн Адьшаа гишүүн, Ганибалын Амартүвшин гишүүн, Норовын Алтанхуяг гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Дашидондогийн Ганбат гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Цэндийн Мөнх-Оргил гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Шатарбалын Раднаасэд гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн, Ням-Осорын Учрал гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн гэсэн ирцтэйгээр хуралдааны ирц бүрдсэн байна. Ингээд Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 3 асуудал байгаа.

1.Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

2.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

3.Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байвал нэрээ өгье. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн алга байна.

Ингээд тэгвэл хэлэлцэх асуудлыг баталсанд тооцъё. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

1 дүгээр асуудал. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье ээ.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Асуулт асуух гишүүн алга байна. Тэгэхлээр тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн алга байна.

Тэгвэл Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит зорилгын 11 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь.

1.Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний

өдрийн Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 173 дугаар захирамжид заасан Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаврыг хавсралтаар баталсугай.

2.Хэлэлцэх хугацааг хуульд тусгайлан заасан болон бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолд ороогүй хууль, Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасны дагуу шийдвэрлэхээр тогтсугай.

4.Энэ тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Хууль зүйн байнгын хороо дарга Цогтбаатарт, хэлэлцэх аасуудлын бэлтгэл хангах, мэргэжил арга зүйн, зохион байгуулалтын туслалцааг үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газрын дарга Өлзийсайханд үүрэг болгосугай.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар.

Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би 2 ч хуулийн төсөл хэлэлцэх эсэх нь дэмжигдчихсэн Байнгын хороо дээр байгаа. Тэрний нэг нь бол Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг өөрчлөх тухай хууль байгаа. Үүгээр прокурорын зөвшөөрөлгүйгээр, шүүхийн шийдвэргүйгээр бусдын нэр

хүндэд халдсан гэдэг агуулгаар шууд цагдаагийн торгууль бичээд, эхний удаа 50 мянга, дараачийн удаа 500 мянга, тэгээд баривчлаад ингээд яваад байгаа. Тийм учраас энэ хуулийн төслийг хэлэлцэж өгөхийг өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Тэгэхээр бас нэг жоохон жоохон тодорхой шинэ сайд очсонтой холбоотойгоор Энхбаяр сайд өөрөө яг Байнгын хорооны дарга байж байхдаа энэ хуулийг дэмжиж хэлэлцэх эсэхийг нь дэмжүүлсэн байгаа. Тэгэхээр шинэ сайд очоод бас тодорхой хэмжээний мэдээллүүдийг нэгтгэж нэмж авах ёстой юм. Тэгээд 12 сард энэ хуулийг хэлэлцэхэд бэлтгэл хангуулж өгөөч ээ гэж байгаа юм.

2 дугаарт нь Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга бас оруулж ирсэн байгаа. Тэр дээр сануулах агуулга бүхий заалттай ийм хуулийн төслийг өргөн бариад, тэр нь хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явж байгаа. Тэгээд энэ хуулийг бас уг нь бол Нямбаатар сайд тухайн үедээ сайд байж байхдаа Засгийн газраас Зөрчлийн хуулийн шинэчилсэн найруулга орж ирнэ. Тийм учраас энэ хуулиудтай хамтатгаж хэлэлцье гээд түр хойшлуулчихсан ийм нэг хууль байгаа. Тэгэхээр энэ 2-ыг шинэ сайд очсонтой холбоотойгоор бэлтгэл ажлыг нь хангуулаад, хэрвээ Зөрчлийн хуулийн шинэчилсэн найруулга орж ирэхгүй бол миний хуулийг дангаар нь хэлэлцүүлээд яваач гэсэн ийм л 2 хүсэлтэй байна.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Таны саналыг би зүгээр ингэмээр байна. Та тэгвэл хуулиа аваад хуулийнхаа төслүүдийг аваад ороод ир хоёулаа наадхыг чинь яриад, тэгээд Хууль зүйн сайдтайгаа нэг зөвлөлдөөдөхье. Тэгээд урагшлуулъя. Миний хувиас бол яг боломжтой байвал би дэмжээд явна.

Ингээд тэгвэл өөр асуулт байхгүй байгаа бол хэлэх үг байхгүй байгаа бол “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх

асуудлын цаглавар батлах тухай”
Байнгын хорооны тогтоолын төслийг
баталъя гэсэн томъёоллоор санал
хураалт явуулъя.

Энэ нөгөө сая тогтоолын
төсөлтэй холбогдуулаад энэ 4 дүгээр
заалт дээр Улсын Их Хурлын Тамгын
газарт тэгээд Өлзийсайханд хаалтад
үүрэг болгосугай гэдгийг Өлзийсайхан
даргад гээд уншчихсан байна шүү. Тэрийг
манайхан засаад тогтоол дээрээ
оруулчхаарай. 85 хувийн саналаар
дэмжигдлээ. Ингээд эхний асуудлыг
хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа орё.
Дараагийн асуудал бол Эрүүгийн хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн
мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны
хэлэлцүүлгийг явуулах байгаа.

Ингээд хуулийн төслүүдийг
Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн
хуралдаанаар хэлэлцүүлэх санал
дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг
бүхий ажлын хэсгийн танилцуулгыг
ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын
гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулна.
Сандаг-Очир гишүүнд микрофон өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны
дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас
2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр
Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн
Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай хуулийн төсөл болон хамт
өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл
баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг
2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн
Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн
хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж,
анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль
зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийг Байнгын хорооны
болон чуулганы нэгдсэн хуралдаанаар
хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах санал,

дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг
бүхий ажлын хэсгийг Хууль зүйн байнгын
хорооны 2023 оны 10 дугаар сарын 25-ны
өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулан,
ажлын хэсгийн ахлагчаар миний бие,
гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн
Ш.Адьяа Г.Амартүвшин, Ц.Мөнхцэцэг,
Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар Б.Энх-
Амгалан нар орж ажилласан болно.

Түүнчлэн ажлын хэсэгт
мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх
үүрэгтэй ажлын дэд хэсгийг байгуулж,
холбогдох судалгаа, мэдээлэл гаргуулан
ажиллаа. Ажлын хэсэг 2 удаа, дэд хэсэг
4 удаа хуралдсан болно.

Хуулийн төслийг D-parliament.mn
цахим хуудаст байршуулан олон нийтийн
саналыг авсан бөгөөд иргэдээс хуулийн
төслийн 3 зүйлтэй холбоотой
давхардсан тоогоор 43 санал ирүүлснийг
ажлын хэсэг нэг бүрчлэн хэлэлцсэн болно.

Байнгын хорооны ажлын хэсэг
2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн
хуралдаанаараа хуулийн төслийг зүйл
бүрээр хэлэлцэж, зарчмын зөрүүтэй
саналын томъёолол 12, хамт өргөн
мэдүүлсэн хуулийн төслийн талаарх
найруулгын 3 саналыг саналын
томъёоллыг хэлэлцэн дэмжиж, Хууль
зүйн байнгын хорооны хуралдаанд
танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Тухайлбал, насанд хүрээгүй хүний
эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг хөөн
хэлэлцэх хугацааг хохирогчийг 18 насанд
хүрсний дараа тоолж эхлэхээр, мөрдөн
шалгах ажиллагааны нууцыг задруулах
гэмт хэргийг өөрчлөн найруулахаар
хуулийн төслийг саналыг хасахаар,
согтуурсан, мансуурсан эсэхийг зохих
журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн
бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг
нэг жилийн хугацаагаар хасаж, 7-30
хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл
оногдуулахаар тусгаж, Зөрчлийн тухай
хуулиас торгуулийн шийтгэлийг хасахаар
томъёоллоо.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, шинээр авах тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Д.Цогтбаатар: Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Мөнх-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Мөнхбаатар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Эрдэм-Ундрах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга Бадамсамбуу, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Нарантунгалаг, Хууль

зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Лхагвацэнд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Нямдаваа, Дотоод хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Гантулга, Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн дарга В.Хосбаяр, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байхгүй байна. Тэгвэл ингээд энэ асуудлаар санал хураалт явуулж эхэлье. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 3 санал байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.” Санал хураалт явуул явуулъя. Асуулт байгаа бол асууя. Раднаасэд гишүүний микрофоныг өгье.

Ш.Раднаасэд: Энэ өнгөрсөн чуулганаар орох байсан тээ. Энэ чинь дахиж яваад байна тийм үү. Хойшилсон шалтгаан нь Дээд шүүх нэг байр суурь илэрхийлээд, тэрийг авч хэлэлцэхгүй бол

болохгүй байна гэсэн. Тэр ямар юм байсан юм. Тийм албан ёсоор энэ тогтолцоонд ч юм уу эрх зүйн юунд нь ерөөсөө бүр болохгүй шинжтэй юм байгаа бол гэсэн юм уу. Тэр талаар нэг тайлбар сонсмоор байх юм. Энэ чинь Байнгын хороогоор 2 дахиа орчхож байна гэсэн үг шүү дээ. Миний ойлгож байгаагаар зөв биз. Чуулганаар орох ёстой байтал.

Д.Цогтбаатар: Ингэсэн. Их Хурлаар оруулахын өмнө бас нэлээн олон асуудлууд дээр зарчмын зөрүүтэй саналууд гараад, ер нь тэгээд нэлээн олон бараг ер нь Сандаг-Очир дарга аа бүх асуудлаар нэмэлт ер нь чиглэл авах шаардлага гарсан. Гүйцээн боловсруулах. Тэгэхлээр тийм олон асуудлаар ер нь гүйцээн боловсруулах чиглэл авч байхаар бид нар ер нь юмнуудаа ахиад нэгтгээд, ажлын дэд хэсгээрээ яриад, тэгээд анхны хэлэлцүүлэгтээ дахин оруулж ирье гэдэг тэр саналыг Байнгын хорооны зүгээс би гаргасан юм. Раднаасэд дарга аа, яах вэ шүүх хариулбал бас эндээс ажлын хэсгээс хариулна биз. Явцын дунд бол ганцхан шүүх биш ер нь олон асуудал дээр гишүүд ч саналууд гаргасан. Зарчмын зөрүүтэй бас нэлээн олон саналууд гарсан. Уг нь орох нь зүгээр гэхдээ жишээлбэл Байнгын хороо дээр хасагдчихсан саналууд ч эд нар байсан. Тийм учраас бид нар эргэж харах юмнууд нэлээн олон байсан. Сандаг-Очир гишүүн нэмж хариулах зүйл байна уу. Ажлын хэсгээс хариулах хүн байна уу. Батцэрэн шүүгч хариулъя.

Б.Батцэрэн: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25.8.3-д хууль, тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын Дээд шүүх саналаа хууль санаачлагчид уламжлах бүрэн эрхийн хүрээнд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хуулийн төслийг нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцсэн. Нэгдсэн саналаа хууль санаачлагчид хүргүүлсэн. Энэ саналыг

ажлын хэсэг дээр нэг бүрчлэн бас хэлэлцсэн байгаа.

Д.Цогтбаатар: Тэгвэл энэ саяын уншиж танилцуулсан томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 78 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “12.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг” гэснийг “12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг” гэж, мөн зүйлийн 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “22 дугаар бүлэгт” гэснийг “22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт” гэж тус тус өөрчлөх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 78 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 3 дахь заалтын 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “10.1 дүгээр зүйлийн 2, 3” гэснийг “10.1 дүгээр зүйлийн 3” гэж өөрчлөх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 78 хувийн саналаар санал дэмжигдлээ. Сандаг-Очир гишүүнийх гагцхисан гэсэн үү. Сая минийх бол дэмжсэн тэгвэл дэмжсэн гэдгээр протоколд оруулчаарай. Сая машин ажилласангүй.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Энэ дээр чинь тэгвэл ийм санал байхгүй байгаа юм байна.

Тэгвэл хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй бол санал хураалт явуулж эхэлье. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье.

4. Төслийн 2 дугаар зүйлийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн

““мэргэжлийн үйл ажиллагаа явуулах,” гэсний дараа “тээврийн хэрэгслийг жолоодох” гэж, мөн хэсгийн “нийтийн албанд ажиллах” гэсний дараа “, тээврийн хэрэгслийг жолоодох” гэснийг ““тохиолдолд” гэсний дараа “тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс арван хоёр жил хүртэл, эсхүл”” гэж өөрчилж, мөн зүйлийн “гэж, 12.3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын “арван зургаан насанд” гэсний дараа “хүрсэн арван найман насанд”” гэснийг хасах. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 92 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүн байхгүй байна. Санал хураалт явуулж эхэлье. Энэ дээр ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 3 Саналтай байгаа.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг хасаж, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хорин” гэснийг “хорин таван” гэж өөрчлөх. Энэ томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6 дээр Хууль зүйн сайд үг хэлье гэсэн үү. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хасах. Энэтэй холбогдуулж Хууль зүйн сайдын микрофон өгье. Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Би энийг бас протоколд бас тэмдэглүүлж үлдээх нь зүйтэй байх гэж бодож байгаа.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хасах гэдэг нь мөрдөн шалгах үйл ажиллагааны нууцыг задруулсан гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн бодлогыг чангаруулах чиглэлээр Засгийн газраас өргөн барьсан заалтыг Улсын Их Хурал дахь манай намын бүлгийн саналын дагуу улс төрийн шийдвэрийн дагуу хасах ийм санал хураалт л даа. Энэ нь бол

Засгийн газраас оруулж ирсэн төсөл нь иргэдийн мэдэх эрхийг хязгаарласан, тэр дотроо хэвлэл мэдээллийн байгууллага сэтгүүлчдийг энэ зүйлээр яллах гэсэн ийм ямар ч 1 дүгээрт санаархал байхгүй, 2 дугаарт энэ зүйл анги нь өөрөө хэвлэл мэдээллийн байгууллага, жирийн иргэд, сэтгүүлчдэд огт хамаагүй заалт байсан. Энэ дээр улс төр хийсэн, явсан, санаатай мушгисан. Энэ бол Монгол Улсад сүүлийн 100 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэмт хэрэг угаасаа эрүүгийн. Шинэ зүйл биш. Энийг шинээр оруулж ирээд иргэдийг яллах гэж байгаа гэдэг ийм асуудлыг зориуд санаатай явсан. Тийм учраас би энийг бас протоколд тэмдэглэж байгаа юм. Хасаж байгаа нь байна шүү дээ. Ингээд энийг хассанаар иргэдийн мэдэх эрх сэргээд тэгээд л хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид хариуцлага тооцох байж байснаа болиод л эд нар тийм ямар ч юм байхгүй. Угаасаа энэ үйлдэл Эрүүгийн хуульд зааснаараа сүүлийн 100 жилд гэмт хэрэг байгаа. Гэмт хэрэг одоо байгаа. Цаашид гэмт хэргээрээ л байна. Гол Засгийн газрын асуудал бол юу гэж ярьсан гэхээр энэ мөрдөн шалгах үйл ажиллагааны арга ажиллагааны нууцыг задруулдаг хуулийн байгууллагын сүлжээ, үүгээр дамжуулж шантааж хийдэг, хээл хахууль авах гэмт хэрэг үйлдэж байгаа, онц хэмжээний мөнгө угааж байгаа ийм үйлдлийг таслан зогсоох, энд ноогдуулах хариуцлагыг чангатгахтай холбоотой Засгийн газрын санал орж ирсэн юм. Энийг бусад улсын хууль тогтоомжтой харьцуулж авч үзсэн. Дэлхийн 50-иад улс орны хууль тогтоомжид энэ үйлдлийг яаж зохицуулж байгаа вэ гэдгийг авч үзсэн. Эх газрын эрх зүйн тогтолцоотой манайхтай адилхан Франц, Германы улсуудад энийг 5 хүртэлх жилийн хорих ялтай байгаа. Энэ гэмт хэрэг нь өөрөө. Манай улсын тухай торгох ялтай байсныг нь торгох ялыг нь больё гэдэг ийм санаачилга гарсан юм шүү гэдгийг би бас протоколд тэмдэглүүлж байгаа юм.

Тэрнээс биш энэ нь ингээд иргэдийн мэдэх эрхийг хязгаарлахад чиглээд л ингээд явсан зүйл бол биш. Иргэдийн мэдэх эрх, хэвлэн нийтлэх эрх угаасаа нээлттэй байгаа. Энэ зөвхөн мөрдөн шалгах үйл ажиллагааны арга тактикийн асуудал яриад байгаа юм. Ажиллагааны нууц л алдагдаад байгаа юм. Ажиллагааны нууцлал. Тийм учраас энэтэй холбоотой асуудлыг бас би ойлголтын зөрөө ингээж гарсан юм шүү. Энийг нэг ойлголтыг нь хүлээн зөвшөөрөөд байгаа юм бол байхгүй. Энэ асуудлаар тодорхой асуудлууд дээр хэрэг бүртгэлтийн хэрэг нь үүсгэж шалгаж байгаа асуудлууд байгаа. Би хэлсэн. Би худлаа ярьдаг сайд байхгүй ээ. Үр дүн гаргана гэж. Тэгэхээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Мөнх-Оргил сайд ч гэсэн хэлсэн энэ асуудлаар бас Хууль зүйн байнгын хороонд гишүүддээ мэдээлэл өгөөрэй гэсэн. Би бас мэдээлэл өгнө гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Тэгвэл ингээд хасъя гэсэн түрүүн би уншиж танилцуулсан хасъя гэсэн томъёоллоор хасахыг дэмжсэе гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Уначихлаа шүү дээ. Тэгвэл энэ хасъя гэсэн санал дэмжигдсэнгүй. Уначихлаа. Тэгэхлээр Мөнх-Оргил сайдад микрофон өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энхбаяр сайд сая тайлбар хэлж байгаад хүмүүсийг будилуулчихлаа л даа. Энэ ажлын хэсгийн дүгнэлт нь зөв юм. Энэ тэртээ тэргүй Эрүүгийн хуульд байгаа заалт байхгүй юу. Мөрдөн байцаах ажлын нууцыг хадгалж байгаа хүмүүс нууцаа задлах юм бол тэртээ тэргүй Эрүүгийн хуулиараа ял хүлээж байгаа заалт. Тийм учраас энэ ажлын хэсгийн дүгнэлт нь зөв юм байгаа юм аа. Тэгээд дэгээрээ энэ асуудлаар, ямар ч асуудлаар санал хураалцчихаад 3 хүртэл удаа санал хурааж болно. 3 хүртэл. Тэгэхээр 2 дахь удаагаа санал хураалгаж өгөөч ээ гэж би санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Би ингээж бодож байна. Ер нь бол чуулган дээрээ ороод тэндээ гишүүд чуулган дээрээ шийдэх нь зөв байх гэж бодож байна. Нэгэнт санал хураагаад сая явчихлаа. Тэгээд энэ санал нь уналаа. Гэхдээ энэ дээр нээрээ нэг зүйл би бас нэмж хэлмээр байгаа юм. Ерөөсөө энэ хууль орж ирснээр юу гэдэг юм энэ хасагдлаа гэж бодъё чуулган дээр. Тэглээ гээд хариуцлагаас бол энэ мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүс бол чөлөөлөгдөхгүй. Энэ хариуцлага нь хэвдээ байж байгаа. Зөвхөн энийг харин бол чангаруулъя гэж оруулж ирж байсан юм байгаа. Тэгээд тэр нь бол ингээд буцаад Байнгын хороо дээр бол сэргээж байна гэсэн үг. Тэгээд чуулган дээр ороод энийгээ шийдэх нь зөв байх гэж бодож байна. Тийм учраас би дахиж санал хураалгахгүй ээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.10 дугаар зүйл.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих

1.Тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.согтуурсан, мансуурсан үедээ;

2.2.тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй хүн;

2.3.хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулж үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс дээш таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс дээш найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

4.1.согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн;

4.2.энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг найман жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Тээврийн хэрэгслийг жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгслийг жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “согтуурсан” гэж шалгаж, тогтоох ажиллагааны үр дүнд шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0.20, түүнээс дээш промилль (%), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0.5, түүнээс дээш промилль (%) илэрснийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгслийн жолооч” гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа тээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй, эсхүл эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүнийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэдэгт согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүнийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгсэл” гэж механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно.” Энэ найруулгын томъёог дэмжье гэсэн ... асуулт байгаа юу. Асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Раднаасэд гишүүнээр тасаллаа. Раднаасэд гишүүний микрофоныг өгье.

Ш.Раднаасэд: Ажлын хэсэг хариулах ёстой юу яах ёстой вэ. Энэ бол нөгөө хаймраар хүн алах, хутгаар хүн алахтай ижилхэн ингээд ингээд явах байх. Энэ ялын бодлоготой холбоотой торгох, нийтэд тустай ажил хийлгэх, хорих, зорчих эрх хязгаарлах гээд 4 бодлого явж байна. Бүгдийг нь зэрэгцүүлээд биччихье. Хатууд нь хатуу, хөнгөнд нь хөнгөн гэдэг зарчмаар хандав уу. Одоо энэ 2017 оны манай энэ Эрүүгийн хуулийн ялын бодлого ч гэсэн их ерөнхийд нь тэгээд л дөхүүлээд л тавьчихсан шүү дээ. Маш их хөнгөхөн болгоод. Энийг орилоод ерөөсөө болоогүй байхгүй юу. Энэ дээр ер нь яг ямар байр суурь барьж ажиллав. Ажлын хэсэг, Хууль зүйн сайд ч байна. Тэгээд нийтэд тустай ажил хийлгэх, хорих, зорчих эрх хязгаарлагдах, торгох гээд аль дуртайг

нь шүүх сонгоно биз гээд сонголтоор. Уг нь эндээс гарахдаа бид нар энэ 4 юмаа тавьж байгаад тэр эрх хасах бол нэмэгдэл хэлбэрээр явж байгаа юм шиг байгаа юм. Эндээс бид нар бодохдоо энэ нь хүнд энэ дээр нь бол хүнд ял өгнө, хариуцлага тооцогдоно. Энэ нь бол арай хөнгөвтөр юм гэдэг ч юм уу. Энийгээ нэг эргэж яаж харсан бэ. Энэ орж ирснээсээ өөрчлөгдсөн үү. Энэ дээр ер нь яг ямар байр суурь баримталсан бэ.

2 дахь юм. Одоо энэ скүүтер гээд нэг юм гарч ирлээ. Бид яах вэ. Механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно гэж байгаа юм. Тээврийн хэрэгсэл гэж. Тэр сурон гээд хүүхдүүд унаад байна. Хаа сайгүй ерөөсөө. Маши өндөр хурдтайгаар. Энэтэй холбоотой ямар нэгэн хариуцлагын юм байна уу. Ер нь нэг мөсөн энэ юмыг оролдсонх энэ замын хөдөлгөөнтэй холбоотой юмаа бүхэлд нь багтааж орж үзэв үү.

3 дахь юм нь энэ бол миний санал. Би зүгээр хүмүүсийн саналыг сонсъя гэж бодоод байна. Болж байна гэвэл би энэ дээр бас саналын томъёолол биччихдэг ч юм уу гээд. Согтуу гэдгийг нь мэдсээр байж чи хүргээд өгчих, чи бариад явчих, чи гайгүй байна шүү дээ гэж нэгнийгээ машин бариулдаг ийм зүйл гардаг. Энэ бол түгээмэл. Болиоч ээ гэж ерөөсөө хэлдэггүйгээр явуулчихдаг. Би бол энэ зорчигчийг нь хамт торгоод хаячихмаар санагдаад байгаа байхгүй юу. Согтуу гэдгийг нь, архи уусан гэдгийг нь мэдсээр байж тэр машинд сууж явах, эс үгүй бол тэр хүнийг машин барих нөхцөлд барихад нь юу гэдэг юм хориглоогүй, цааргалаагүй, зогсоогоогүйн төлөө тэр зорчигчийг хамт торгох ийм хариуцлагын төрөл энэ тал дээр энэ гадна дотнын юм та нар судалж үзсэн үү. Ажлын хэсэг байх уу, энэ тээврийн цагдаагийнхан байна уу. Ийм 2 төрлийн багц асуулт байна.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. Батцэрэн шүүгч 5 дугаар микрофон өгье.

Б.Батцэрэн: Тэгэхээр Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйл тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмыг зөрчих гэсэн энэ зүйл хэсэгт хууль санаачлагч 2 зүйл хэсгийг нэмэхээр оруулж ирсэн. Хууль зүйн байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу анх удаа согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон бол Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд зааснаар хариуцлага хүлээлгэе. Харин эрх нь сэргээгдээгүй байхад давтан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр ингэж томъёолол хийе гэсний дагуу ажлын хэсэг ажиллаж, энэ 5 дахь хэсгийн томъёоллыг бол бэлтгэсэн. 6 дахь хэсэг нь болохоор энэ зөрчлийг дахин гаргасан бол гэдэг томъёолол байсан. Тэгэхээр энийг бол ажлын хэсэг хассан. Хасах санал гаргасан. Үндэслэл нь бол 2015 онд Эрүүгийн хуулийг батлахдаа давтан гэмт хэрэг үйлдсэн гэдэг шинжээр эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх тэр ялын бодлогыг бол халсан байгаа. Дээр нь ялтай байдал гэдэг хууль зүйн ойлголтыг мөн Эрүүгийн хуулиас хассан. Тэгэхээр үүнтэй холбогдуулаад энэ 6 дахь заалтыг 5 дахь заалттай нэгтгээд, нэгтгэсний улмаас энэ Раднаасэд гишүүний асууж байгаа энэ Эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээнүүдийг нэг дор ингэж тавьсан байгаа. Өөрөөр хэлбэл энэ хүний анх удаа гэмт хэрэг үйлдсэн, тэр согтуурлын зэрэг, бусад нөхцөл байдлыг харгалзаад тэр хуульд заасан төрөл хэмжээний аль хэсгийг оногдуулах вэ гэдгээ бол шүүх шийдвэрлэнэ. Энэ бол шүүгчийн бүрэн эрхэд хамаарах асуудал. Харин энэ зөрчлийг дахин дахин гаргаад байгаа бол тэр байдлыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6 дугаар зүйлд заасан хүндрүүлэх нөхцөл байдалд тооцож, эрүүгийн хариуцлагыг чангатгаж оногдуулах энэ агуулгаар торгох, мөн нийтэд тустай ажил хийлгэх, мөн зорчих эрхийг хязгаарлах, мөн хорих ялын төрөл хэмжээнүүдийг хуульчилсан байна. Эхний асуудлын хувьд бол ийм байна.

2 дахь асуудал бол тээврийн хэрэгсэл гэдэгт механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно гэж байгаа. Энийг бол энэ хууль зүйн ойлголтод цахилгаан эх үүсвэрээр явдаг мопед хамаарах уу гэж. Тэгэхээр хамаарахгүй. Энэ замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэж орсон. Тэр гэрээнд бол тэр мопедыг бол тээврийн хэрэгсэлд оруулахгүй байхаар ингэж заасан байдаг. Гэхдээ хөдөлгүүрийн багтаамж нь ер нь механикжсан тээврийн хэрэгслийн хувьд бол 50см куб багтаамжаас дээш ийм хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг бол механикжсан тээврийн хэрэгсэлд тооцдог. Гэхдээ хурдны хувьд, хүчний хувьд, жингийн хувьд энэ 50см куб механикжсан тээврийн хэрэгсэлтэй дүйцэх хэмжээний ийм цахилгаан эх үүсвэрээр явдаг мопедыг механикжсан тээврийн хэрэгсэлд оруулан тооцох боломжтой.

Д.Цогтбаатар: Раднаасэд гишүүн тодруулъя.

Ш.Раднаасэд: Үгүй ээ, энэ сурон гээд 80км цагийн хурдтай явж байна шүү дээ. Одоо хамгийн дээд тал нь. Дан 7, 8, 9 дүгээр ангийн хүүхдүүд унаж байна. Аягүй бол зарим нь 5, 6 ч байж магадгүй. Энийг оруулах уу, оруулахгүй юу.

2 дугаарт яг энэ торгуулийнхаа хэмжээг байна шүү дээ. Анх удаа увал тэдэн төгрөг увал гэнэ, анх удаа согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодвол анхны удаа тэдэн төгрөг ч гэдэг юм уу мөнгөн дүнгээр нь ярихгүй бол тэдэн нэгжтэй, эдэн нэгжтэй гэхээр энэ ард түмэн нийгэм ойлгохгүй байна л даа. Тэрийг мөнгөн дүнгээр нь маш тодорхой хэлээд өгчих. Энэ хэвлэлийнхэн суугаад байгаа учраас энийг бас мэдээлчих нь зөв байх.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон дээр ажлын хэсгээс хариулъя. 4 дүгээр микрофоныг өгье.

В.Хосбаяр: Та бүхний энэ өдрийн амрыг эрье. Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Тэр скутерийг тээврийн хэрэгсэлд орох уу гэсэн асуулт асууж байна. Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйл дээр тээврийн хэрэгслийн тухай тодорхойлолтыг тусгаж өгсөн байдаг. Тэгэхээр тээврийн хэрэгслийг үндсэндээ 2 ангилж байгаа юм. 1 дүгээрт механикжсан тээврийн хэрэгсэл буюу тусгайлсан сургалтад хамрагдаж эрх авдаг, тусгай хөдөлгүүрээр тоноглогдсон, орчиндоо аюултай тээврийн хэрэгсэл буюу автомашин, мотоциклыг механикжсан тээврийн хэрэгсэл гэж үзэж байгаа.

Нөгөө 2 дугаар ангилал нь бол насны ангиллаар жолооддог тусгайлсан эрх авдаггүй, нөгөө түрүүний яриад байгаа мопед, сурон гэх .../минут дуусах/

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон өгье.

В.Хосбаяр: Тэгээд нөгөө насны ангиллаар барьдаг тээврийн хэрэгсэл нь скутер, унадаг дугуй, тэгээд нөгөө хүн уналга ачлагад зориулсан мал амьтан түүнд хөллөсөн ердийн хөсөг, хэрэгслийг ингэж хэлж байгаа юм. Ингээд 2 ангилж байгаа юм. Тэгэхээр энэ 2 дугаар ангилалд багтаж байгаа тээврийн хэрэгсэл дээр бол тусгайлсан эрх авдаггүй ийм зохицуулалттай байж байгаа. Мөн замын хөдөлгөөний дүрмийн 1.2.24 дээр түрүүн Батцэрэн шүүгч хэлсэн 50м3-ээс хэтрэхгүй хөдөлгүүртэй мөн 0,25квт-4квт хүртэл хүчин чадалтай хэрэгслийг мопедын ангилалд багтаагаад байгаа юм. Тэгэхээр 0,25-4 хүртэл киловаттаас давчих юм бол нөгөө тээврийн хэрэгслийнхээ ангилал руу орчих юм.

Тэгэхээр Монгол улс бол 1997 оны Замын хөдөлгөөний Венийн конвенцод нэгдэн орсон. Тухайн Венийн конвенц дээр мөн шаардлагатай бол тухайн Венийн конвенцод нэгдэн орсон орон мопед буюу

энэ мопедын ангилалтай мопедын хөдөлгүүртэй дүйцэх ийм унаа хэрэгслийг тээврийн хэрэгсэл гэж үзэж болно гэсэн ийм ойлголттой тайлбарласан байж байгаа.

Д.Цогтбаатар: Ингэе хэдүүлээ наадах чинь зүгээр микрофоноос гадуур яриа болоод хувирчхаад байна. Ажлын хэсгээс би нэг юм асуучихъя. Тэр эхний нөгөө юу эрх авах шаардлагагүй сурон нь байгаад байна шүү дээ. Тэгээд нөгөө жижиг хүчин чадал багатай. Тэрний хурд нь ердийн дугуйгаар хүүхдүүд унаад явж байна шүү дээ. Тэр дээр бол ямар нэгэн эрх авах шаардлагагүй байгаад байгаа шүү дээ. Хурдны хувьд тэр ердийн дугуйтай адилхан байгаад байгаа учраас тийм юу шаардахгүй гэж байгаа юм уу. Тэгэж ойлгож болох уу. Тэгээд тэрнээс илүү хүчин чадалтай болоод ирэхээр эрх шаардаж байгаа. Тэр нь бол ердийн дугуй биш. Мопед шиг ч юм уу, мотоцикл шиг хурдтай болж байна гэж тэгж ялгаж байгаа юу. 4 дүгээр микрофон өгье.

В.Хосбаяр: Түрүүн хэлсэн байж байгаа. Замын хөдөлгөөний дүрмийн 1.2.24 дээр энэ 50мЗ хүртэл хүчин чадалтай 0,25-4квт хүртэл ийм хөдөлгүүртэй мопед буюу энэ сурон, скүүтрийг адилтгаж үзээд байгаа юм. Энэнээсээ давчих юм бол яг шууд механикжсан тээврийн хэрэгсэл гэж үзнэ гэсэн заалт бол байхгүй. Гэхдээ хэрвээ үүнээс давах юм бол механикжсан тээврийн хэрэгсэлд оруулж тооцоод тухайн шүүхийн шинжилгээний ерөнхий газраа дүгнэлт гаргасны үндсэн дээр энэ ангилалд багтаах боломжтой байж байгаа юм.

Д.Цогтбаатар: Харин миний асуугаад байгаа чинь тэгэхээр тэр 2 ангиллаар хуваагаад байгаа нь тэр доод ангиллын юу нь байна шүү дээ тэр нь явах хурд нь ердийн дугуйтай адил. Цаад логик нь юу юм. Эсвэл зүгээр л техникийн тийм шаардлага, тийм стандарт олон улсад байдаг болоод тэгээд байгаа юм уу.

В.Хосбаяр: Энэ дээр нөгөө хурд хүч, эрсдэл, аюул тэр нөгөө хөдөлгүүрийн багтаамж энэ тэр гээд бүх зүйл нь орж байгаа. 50мЗ, 0,25-4 гэдэг энэ 2 ойлголтод бол тэр хурд хүч бүх юмыг нь л оруулж ойлгож байгаа байхгүй юу. Тэгээд үүнээсээ илүү давчих юм бол механикжсан тээврийн хэрэгсэл гэж үзэх боломжтой л гэж. Өөрөөр хэлбэл үүнээсээ давчих юм бол тусгай эрх шаардаад жолоодох эрхийн үнэмлэх авч байж тухайн тээврийн хэрэгслийг жолоодно гэж ойлгож болно.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Раднаасэд гишүүн тодруулаад асуучихъя.

Ш.Раднаасэд: Үзэхэд байна шүү дээ хамгийн сүүлийн үеийнх 140км цагийн хурдтай, 12,5квт тог зарцуулдаг. Цагт нөгөө хурд байна шүү дээ. 440. Тэгээд 50 гэдэг чинь бол хоцрогдчихоод байгаа байхгүй юу. 440-ийн багтаамжтай 440 нь ямар хэмжээ байсан юм. Мэдэхгүй. Тэгээд энийг бол насны ангиллаар ингээд хүүхдүүдэд бариулна гэдэг өөрөө шууд замыг нь засаад өгчхөж байгаа байхгүй юу. Бурхан руу явуулах. Энийгээ зохицуулахгүй бол энэ одоо бол байгаагаар бол 50мЗ тээ. Тэрэндээ тааруулаад багтахгүй юм байна гээд нас руу нь оруулаад л ингээд л явчихдаг л юм байна л даа. Ямар ч зохицуулалтын юм бол .../минут дуусав/

Д.Цогтбаатар: 4 номерын микрофон өгье.

В.Хосбаяр: Моторынхоо нөгөө хөдөлгүүрээс үл хамаараад тэр 0,25-4 хүртэл гэж байгаа. 4-өөс дээшээ л гарчих л юм бол механикжсан тээврийн хэрэгсэл гэж үзнэ. Ганбат гишүүн. Тэгэхдээ Ганбат гишүүн ээ, яг ийм юунууд дээр хэдүүлээ саналаа өгч байж асууцаана шүү. Би энэ удаа танд өглөө.

Д.Ганбат: Баярлалаа. Яах вэ, ингээд ярилцаад эхлэхээр чинь амьдрал хууль 2 чинь хамаагүй ялгаатай харагдаад байна л даа. Бид нарын энэ

батлах гэж байгаа хууль чинь яг тэр зам дээр болж байгаа Улаанбаатарт Монгол Улсад болж байгаа энэ юмыг зохицуулж чадах юм уу, чадахгүй юм уу гэсэн ийм юм болчихоод байна шүү дээ. Тэр хаа байсан 1997 оны конвенц одоо 2023 он. Тэгээд би нэг юмыг тодруулмаар байна. Сая Раднаасэд гишүүний асуугаад байдаг тэр сурон чинь хаагуур зорчих ёстой юм бэ. Бид нарт тэр зам нь алга. Тэр скүүтер чинь, тэр сурон унасан хүүхдүүд чинь тэр хамгаалалтын малгай бээлийтэй байх ёстой юм уу, үгүй юм уу. Яг тэр автомашинтай зэрэгцээд яваад байх ёстой юм уу, үгүй юм уу. Тэр чинь автомашинтай зэрэгцээд дотор нь яваад байхаар чинь замын хөдөлгөөний дүрмийн наад захын юмыг мэдэх ёстой байх. Тэгж байж оролцох ёстой байх. Тэгээд ингэж оролцож байгаа энэ хүүхдүүд залуучууд ямар нэгэн аваар осолд орж байна уу, орохгүй байна уу. Хэрэв хүн гэмтээж байна уу, үгүй юу гэсэн ийм асуултууд байна л даа. Тэгээд бид нарт ямар дутагдал байна вэ гэхээр бид бүхэн бол ерөөсөө хуулийг ингээд ганц нэг заалтаар нь өөрчлөөд байдаг. Хуулийг бүхэлд нь олж, бүхэлд нь харж өөрчлөлтөө хийхгүй, тэгээд 1 юмыг нь болгох гэж байгаад, нөгөө юмаа байхгүй болгоод ингээд бүрэн зохицуулж чадахгүй ийм юм гарчхаад байх шиг харагдах юм. Тэгээд амьдрал дээр өнөөдөр ингээд явж байхад бол тэр дотор чинь скүүтер унасан залуучууд ч явж л байна. Тэр автомашин зорчих ёстой замаар нөгөө Сурон гэдэг мотоциклыг чинь уначихсан явж л байна. Тэгээд тэр чинь хүнийг гэмтээдэг юм уу, гэмтээдэггүй юм уу. Тэгээд мөргөлдчихвөл алиных нь буруу юм. Тийм тусгай зам байх ёстой юм уу, үгүй юм уу гэсэн ийм хэдэн асуултууд байна л даа. Бусад улс оронд бол тусдаа замтай зорчдог барьдаг тийм газартай ийм байдаг. Манайд чинь тийм юм алга л байна шүү дээ.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон.

В.Хосбаяр: Ганбат гишүүний асуултад хариулъя. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжид бол 3.1.4 дээр зам гэж тээврийн хэрэгслээр зорчиход зориулсан зурвас газрыг хэлдэг. Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжид ердийн хөсөг буюу мопед, сурон, скүүтерийг өөрөө хэлж байгаа юм. Энэ нөгөө насны ангиллаар жолооддог тээврийн хэрэгслийг бол замаар зорчихыг бол зөвшөөрч байгаа. Яг зөв зорчих хэсэг дээр бол зорчих хэсгийн хамгийн баруун эгнээгээр явахыг замын хөдөлгөөний дүрэмд хуульчилж, зааж өгсөн байдаг. Аюулгүй байдлын тухай хууль тогтоомж дээр. Тэгээд энэ сурон болон энэ скүүтертэй холбоотой зам тээврийн ослууд ер нь хэрхэн ямархуу байдалтай, ямар нөхцөл байдалтай гарч байна гэсэн асуулт маань асууж байна. Мопедтай холбоотой зам тээврийн осол бол энэ он гараад хүний яг эрүүл мэндэд хохирол учруулсан 2 осол бүртгэгдсэн байж байгаа. Мөн сурон болон энэ улирлын чанартай сорон, скүүтертэй холбоотой хүний эрүүл мэндэд хохирол учруулсан хэргүүд бол бүртгэгдсэн байж байгаа. Ингэхдээ бол хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан хэлбэрээр ийм тохиолдлууд бол бүртгэгдэж байна.

Тэгээд нэмээд хэлэхэд тэр тээврийн хэрэгслийг бол 2 ангилж байгаа. Тэгэхээр ердийн хөсөг буюу насны ангиллаар жолооддог тээврийн хэрэгсэл дээр энэ скүүтер, сурон гэдэг бол өөрөө цахилгаан тээврийн хэрэгслийн нэг брэндийн нэршил байхгүй юу. Тэгэхээр эдгээр цахилгаан тээврийн хэрэгслүүд бол бүгдээрээ тээврийн хэрэгсэлдээ ороод явж байгаа. Тэгэхээр өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль дээр бол үүнийг нийцүүлээд явахад бол ямар нэг асуудал гарахгүй гэж ойлгож болно.

Д.Цогтбаатар: Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Сая бас нөгөө сурон, скүүтер нөгөө мопед гээд бас олон асуудал хөндөгдсөн. Хариулж байгаа хариултуудаас болох ч юм шиг, болохгүй ч юм шиг хөдөлгөөнд оролцож, насанд хүрсэн унах ч ёстой ч юм шиг, хүүхэд унах ёсгүй ч юм шиг, ёстой ч юм шиг гээд ерөнхийдөө бас нэг тийм тодорхойгүй, хангалттай биш хариултууд гарч байна. Тэгээд гарцаа байхгүй бас нийгмийн анхаарал татсан асуудал бас мөн үү мөн. Ялангуяа зуны улиралд бол тэгээд л хүүхдүүд 10 настай, 12 настай тэгээд л насанд хүрээгүй 14 настай хүүхдүүд унаад л зарим нь сундалдаж аваад л скүүтэртэй зам төв зам дээр явж байдаг. Зарим нь скүүтэртэй тэгээд л гэнэт давхиж л байдаг. Хамгийн гол нь тэр чинь нөгөө ямар ч дуу чимээгүй явдаг учраас жолооч нарт мэдрэх, анхаарах тийм бололцоо байдаггүй. Тэгээд хүүхдүүд өөрсдөө эцэг эхчүүд нь хүүхдүүддээ анхаарал тавьдаггүй. Хүүхдүүд өөрсдөө мэдээлэл байхгүй, энэ талын мэдлэг байхгүй. Болох, болохгүй талаар. Ийм учраас аваар осол их гардаг, үүнээс болж хүүхдүүд бас амь насаа алдах ийм эрсдэлүүд ч бас тохиолдоод байгаа. Тийм болохоор манай тээврийн цагдаагийнхан, өөр холбогдох байгууллага юу байдаг юм. Прокурорын байгууллага өөр юу яаж болох уу, манай яамныхантай хам хамтраад хотынхон бас бүгдээрээ нэг шийдэл гаргая. Ирэх хавар гэхэд бүгдээрээ энийг ямар байдлаар шийдэх ёстой юм. Олон нийтэд сурталчлах, таниулах, тодорхой хууль, эрх зүйн зохицуулалтуудыг хийгээд, шаардлагатай бол Улсын Их Хурлаар хууль батлуулах шаардлагагүй, дүрэм журмын хүрээнд стандарт, норм, нормативтай өөрчлөх хүрээнд шийдчихээр бол ингээд шийдээд бүгдээрээ бас хамтраад ажиллая. Би бас яамныхандаа бас үүрэг өгчихсөн байгаа. Авто тээвэр үндэсний төв, манай тээврийн цагдаагийнхан бас хамтраад ажиллаадхаарай. Ингээд нэг шийдэл гаргахгүй бол тэгээд л хүүхэд мэддэггүйгээс болж хамгийн гол нь тэр

хүүхдүүд чинь мэддэггүй байхгүй юу. Аав ээж нь хэлдэггүй, анхаарал тавьдаггүй. Тэгээд л хөөрхий амьтад хөөрч явж байгаад л тэгээд л хүүхэд л юм чинь тэгээд л хүүхэд шүү дээ. Тэгээд иймэрхүү байдлаар бас амь насаа алдах тийм асуудлыг бас бид нар анхаарах ёстой. Тэгээд манай яамныхан болон холбогдох хүмүүс хамтарч ажиллая. Байнгын хорооны дарга аа, нэг шийдэл гаргая.

Д.Цогтбаатар: Тэгвэл ингээд үүгээр асуух асуултуудаа тасалъя. Сая Бямбацогт гишүүний хэлж байгааг тал талдаа тэгвэл манай ажлын хэсгийнхэн анхаараад авчих. Нээрээ энэ асуултууд тэгээд хариулж байгаа байдлаас юу ажиглагдаж байна гэхлээр мэдээжийн хэрэг өнөөдрийн манай хууль дүрэм бас өчигдөр гэнэт гараагүй болохлоор зохицуулж байгаа юмнууд байгаа. Гэхдээ амьдралаас хоцроод байгаа нь яг энэ асуултаас харагдаад байна шүү дээ. Хүн ингээд нарийвчлаад асуухаар цэвэр техникийн хариулт өгөөд. Гэхдээ наадах чинь өөрөө цаанаа эрх зүйн аягүй үндэслэл логиктой юмнууд байж байгаа шүү дээ. Тэгэхлээр тэрийгээ та нар тал бүрээсээ ер нь хараад, ялангуяа энэ сурон дээр бол эцэг эхчүүд бүгдээрээ л хаа хаанаа их болгоомжлолтой байж байгаа. Тэгэхээр энэ дээр нь нээрээ нарийвчилж боловсруулах юм байвал би нарийвчлах нь зөв байх гэж бодож байна. Тэгээд Бямбацогт сайдын гаргаж байгаа саналыг бол би дэмжиж байна. Манай Байнгын хорооны зүгээс бид нар яаж дэмжих боломжтой байна. Бас бүх талаараа дэмжээд явъя. Бид нар энэ асуудлаар бас чиглэл өгөөд, Бямбацогт сайд танай яам руу чиглэлийг нь бид нар явуулъя. Ингээд манай ажлын хэсгийнхнээс ч гэсэн энд ороод ажиллаад, илүү боловсронгуй болгоё.

Тэгээд саяын найруулгын юугаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ингээд 92 хувийн саналаар энэ саяын найруулгын томъёолол дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт алга байна. Ингээд ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье.

8.Төслийн 4 дүгээр зүйлийн ““10.1 дүгээр зүйлийн Тайлбарын “арван дөрвөн” гэснийг “арван зургаан” гэж, “12.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэснийг, мөн зүйлийн “2.1 дэх заалтын “арван дөрвөөс” гэснийг “арван зургаагаас” гэж, мөн зүйлийн”” гэснийг тус тус хасах. Санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор. 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Раднаасэд гишүүнээр тасалъя. Раднаасэд гишүүнд микрофон өгье.

Ш.Раднаасэд: Би энэ нэг зүйлийг л оруулчихвал яадаг юм бол гээд. Нийгэм бариад идчихдэг юм болов уу. Энэ архи уусныг нь мэдсээр байж машинд нь хамт суугаад яваад байгаа нөхдүүдийг хамтад нь торгоод хаячихвал яадаг юм бэ. Үгүй ээ, харин тийм л дээ. Би тэрийг чинь мэдээд байна. Тэгэхдээ тэр өөрийнх нь амь насны эсрэг рүү явж байна гэдгийг нь бас тэр нөхөр мэдэж байх ёстой биз дээ. Пүрэвдорж 120-д явж байхдаа ганцаараа явсан уу, хоёулаа явсан уу. Чамайг архи уугаад суугаад явахыг чинь жишээлбэл хүн болиоч ээ гэж хэлэх ёстой байсан уу, үгүй юү гэдгээс л юм яригдах ёстой байх. Тэгээд ертөнцийн 3 хэцүү гэж байдаг юм шүү дээ. Энэ хууль гарснаар яах вэ, хэрэгжих үедээ хэрэгжих л байх. Нөгөө өрөнд орсон

Хятад нэг хэцүү, архи уусан Монгол нэг хэцүү гэдэг шиг. Галзуу солиотой ч биш л дээ. Энэ чинь дэлхийд байдаг жишиг л байхгүй юу. Энэ дээр ажлын хэсэг яг иймэрхүү гадна дотнын янз янзын юм ер нь судалж үзсэн юм байна уу.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. Гэхдээ энэ баруунд бол байдаг зүйл шүү дээ. Тэгэхээр ажлын хэсгээс хэн хариулах вэ. Мөнх-Эрдэнэ зөвлөх. 3 дугаар микрофон өгье.

Д.Мөнх-Эрдэнэ: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Ер нь манай Зөрчлийн хуулийн 14.7 дугаар зүйлийн 55 дахь хэсэг дээр энэ согтуу хүнийг тээврийн хэрэгсэл жолоодохыг шаардсан тохиолдолд хувь хүнийг 20 мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг 300 мянган төгрөгөөр торгох ийм зохицуулалт байдаг. Ер нь яах вэ, бид энэ хуулийн төслийг боловсруулах явцдаа харьцуулсан судалгаа хийсэн. Энэ харьцуулсан судалгааг бид бол зарим улсад тэр дундаа Японд бол жишээ нь согтуу хүнд тээврийн хэрэгслийн жолоо шилжүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ийм зохицуулалт байна лээ. 500 мянган иенээс илүүгүй торгууль ноогдуулах, эс үгүй бол хорих ял ч гэдэг юм уу ийм зохицуулалт байна лээ. Яг бид нарын хувьд бол төсөл дээр тусгаагүй байгаа гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Одоохондоо бол тэгэхээр ийм асуудал байхгүй байгаа юм байна. Өөр асуулт байхгүй бол энэ дээр санал хураалт. Энэ чинь нөгөө Зөрчлийн хууль руу би орчихсон байж байна л даа. Тэгэхдээ энэ Зөрчлийн хуулиар би нэгэнт эхлүүлчихсэн болохлоор энийгээрээ санал хураачхаад. Би түрүүний нөгөө Эрүүгийн хууль дээр 2 зүйл орчихсон байна. Энийгээ эргээд бас хэлэлцээд санал хураачихъя. Гэхдээ эхлээд энийгээ дуусгаадахъя. Нэгэнт эхэлчихсэн болохлоор.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал

хураалт явуулж эхэлье. 2 саналтай байгаа. Тэгээд эхлээд 1 дэхээр нь санал хураачхаад би буцаад тэр Эрүүгийн хууль руу орохгүй бол тэнд орхигдоод явчихсан байна шүү.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, шинээр авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт, хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана.”
Үүгээр асуулт асуух гишүүн байна уу. Амартүвшин гишүүнээр тасалъя. Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Ажлын хэсгийн хурал дээр бид нар энэ заалтыг хэлэлцээд торгуулиа төлөх тэр хөшүүрэг нь хангалттай биш байна гэж ярилцсан юм. Тэгээд ажлын дэд хэсэгт Байнгын хороонд орж ирэхээс өмнө томъёолоо өөрчлөөд оруулж ирээрэй гэсэн. Энэ бол өөрчлөгдөөгүй орж ирж байна л даа. Ер нь бол нийслэлийн том асуудал чинь тэр шүү дээ. Пүрэвдорж гишүүн ээ, би тэгээд. За за больё больё.

Д.Цогтбаатар: Үгүй ээ, Пүрэвдорж гишүүн ээ, үг тасалчихсан шүү дээ. Амартүвшин гишүүн нэгээрээ асуултыг нь асуулгачих тэгэх үү. Тэгээд хариултаа явуулъя хэдүүлээ.

Г.Амартүвшин: Би асуултаа дахиад асууя. Хэлэлцэж байгаа саналын томъёолол дээр ажлын дэд хэсгээс илүү нөлөөлж болохуйц тийм хөшүүрэг оруулж ирье гээд бид нар ажлын хэсэг дээрээ ярьсан шүү дээ. Одоо энэ

торгуулиа төлөхгүй яваад байгаа жолоочыг яаж торгуулийг нь төлүүлэх вэ. Энэ дээр нь та нар нэг хариу өгөөч.

Д.Цогтбаатар: Энэ дээр ажлын хэсгээс Сандаг-Очир гишүүн хариулах уу. Эсвэл ажлын хэсгээс хариулах уу. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Амартүвшин гишүүний асуусан асуулт бол энэ зөрчил үйлдсэн хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл хүсэх, сунгах, тендер шалгаруулалтад оролцох, төрийн жинхэнэ албаны шалгалт өгөх, үндэсний гадаад паспорт авах тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, шинээр авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана гэж ингэж өргөн барьсан хуулийн төслөөр ийм байсан. Тэгээд энийг бас ажлын хэсэг дээр ярьж байгаад ер нь бол торгох шийтгэл чинь бол олон янз. Зөвхөн тээврийн хэрэгслийн зөрчил дээр торгох шийтгэл биш. Эрчим хүчний улсын байцаагч гэдэг юм уу, хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг юм уу, татварын улсын байцаагч гэсэн тодорхой торгох шийтгэл оногдуулдаг. Гэхдээ энэ тээврийн хэрэгслээр зорчсон энэ гэмт хэрэгт зөрчилд тээврийн хэрэгсэлтэй гаргасан тэр зөрчилтэй нь холбоотой л энэ хязгаарлалтын журмуудыг нь оруулж өгье. Тэгэхгүй болохоор хүний эрхийг хязгаарласан энэ олон заалтуудыг оруулах нь бас одоо боломжгүй байна. Тийм учраас эд нарыг нь аваад тээврийн хэрэгслийн зөрчилтэй холбоотой тэр заалтуудыг нь л хязгаарлах заалт дээр оруулж ирье л гэдэг ийм юм ярьсан. Тэгээд Амартүвшин гишүүн түрүүн ажлын хэсэг дээр санал хураагаад цөөнх болсон л доо. Мөнхцэцэг гишүүн 2 бол хуучин өргөн барьснаар нь тэр олон нөгөө хөшүүргүүдийг хэвээр нь үлдээе гэдэг энэ саналыг бол гаргасан. Тэгээд цөөнх болсон. Тэгээд ажлын

хэсгийн томъёолол дээр бол тэрийг нь хасаад ингээд оруулж ирж байгаа. Ийм л зарчмын зөрүүтэй санал. Энэ дагасан зөрчлийн хуулийн 1 дүгээр зүйл дээр.

Д.Цогтбаатар: Би нэг асуулт асуучихъя. Энэ дээр нээрээ тэр ингээд хууль санаачлагчийн зорилго нь бол аль болох мэдрэгдэхүйц, төлсөн нь дээр байхуйц ийм санкцуудыг л уг нь оруулах гээд оролдсон байгаа шүү дээ. Тэгээд бид нар заримыг нь хасъя, зарим нь үнэхээр хамааралгүй юм байна гээд ярьж байсан. Гэхдээ нэг ийм зүйл асуумаар байна. Одоо яг энд ингээд нэр дурдаж байгаа арга хэмжээнүүд байна шүү дээ. Эндээс хамгийн бодитой яг хүнд өдөр тутам мэдрэгдээд төлөхгүй явбал зүгээр явуулахгүй байгаад сануулаад байх санцү нь аль вэ. Одоо энэ дотроос. Тэгэхгүй бол өнөөдрийн энэ торгуулийн тогтолцоо чинь ийм юм байна лээ. Хүн нөгөө жишээлбэл камераа зөрчил камерт бүртгэгдчихэнгүүт торгуулийг нь биччихдэг. Төлье гэж байгаа хүн өөрөө зүгээр мэдэхгүй яваад байх тохиолдол аягүй их юм байна лээ. Тэгэхээр тэр нөгөө мэдэхгүй явж байгаа хүн бол төлөхгүй тийм атгаг санаатай хүн биш байна шүү дээ. Тэгэхэд тэр хүнд сануулаад та ийм өртэй байна шүү, энийгээ төлөхгүй бол таны ажил чинь нэг газар очоод л гацдаг байх. Тэгэхээр тэрийг мэдрүүлэх яг арга хэмжээ энэ дотор аль бэ. 1, 2 тийм арга хэмжээ хэлж өгөөч. Хэн хариулах вэ. Мөнх-Эрдэнэ.

Д.Мөнх-Эрдэнэ: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ зөрчил гаргаад торгуулчихсан этгээд торгуулиа төлөхгүй байгаа байдал бол манайд бол хавтгайрчихсан байгаа. Жишээ нь энэ жилийн бид нарт байгаа статистик мэдээлэл 90 гаруй тэрбум төгрөг төлөгдөөгүй байгаа. Жишээ нь 50-аас дээш удаагийн үйлдлээр энэ торгуулиа төлөөгүй төлбөрийн хэмжээ 4 тэрбум гаруй төгрөг хүрчихсэн ийм байж байгаа юм. Ийм олон хүмүүс байна. Бараг 3 мянга гаруй хүн байна.

Зөрчил гаргаад төлөхгүй байж болдог. Энэ зөрчил гаргачхаад шийтгэл хүлээхгүй байгаа байдал нь өөрөө дараа дараагийн илүү ноцтой үр дагавартай гэмт хэрэг хүний амь нас, эд хөрөнгө, эрүүл мэндэд хохирол учруулж байдаг ийм үр дагавартай үйлдлүүд байдаг. Жилд дунджаар 110 хүн амь насаа алдаж байна гэдэг үүний жишээ. Үгүй ээ, нөгөө хаширч өгөхгүй байна шүү дээ. Тэгэхээр энэ ял шийтгэлийн эрүүгийн хариуцлагын чинь зөрчлийн ч бай энэ нэг шийтгэлийн нэг гол зорилго бол урьдчилан сэргийлэх ийм хэрэгсэл байдаг. Үр нөлөө байдаг. Тэгэхээр бид бол яах вэ, гаднын жишээнүүдийг бас харсан. Герман жишээ нь торгуулиа төлөхгүй байгаа тохиолдолд 6 7 хоногоос хэтрэхгүйгээр олон удаагийн зөрчил давтагдсан тохиолдолд 3 сар хүртэл хугацаагаар баривчилдаг. Баривчлагдсан нь өөрөө торгууль төлөх шийтгэлээс чөлөөлдөггүй. Австрали жишээ нь та хуульд заасан хугацаанд торгуулиа төлөөгүй бол 28 хоногийн хугацаатай зарим мужид шүү. Муж болгон өөр зохицуулалттай. Жишээ нь нэг мужид бол тэгж байгаа юм. 28 хоногийн хугацаатай мэдэгдэл хүргүүлнэ. Энэ хугацаанд төлөхгүй бол 65 Австрали долларын торгууль төлнө. Дахиад төлөхгүй бол танд дараагийнх илүү хариуцлагатай хатуу арга хэмжээ авч эхэлдэг. Жишээ нь жолоодох эрхийг нь хасна, дараагийнх нь арга хэмжээ дахиад нэг арга хэмжээ бол банкн дахь хөрөнгийг нь хөрөнгөөс нь банкн дахь данснаас нь авна. Эд хөрөнгийг нь албадан хурааж борлуулах хуба замаар торгуулийг төлүүлэх ч гэдэг юм уу ийм. Зарим мужид нь бол Австралийн тэр хойд хэсгийн мужууд дээр жишээ нь нийтэд тустэй ажил хийлгэх ийм шийтгэлийн төрөл байгаа гэх мэтчилэн ингээд хариуцлага байгаа. Тэгэхлээр бид нарын хувьд бол энэ хязгаарлаж байгаа арга хэмжээ бол ер нь бол болно. Эхний ээлжид ингээд явж байхад болно. Тэгэхдээ бол бусад улстай харьцуулахад бол үр нөлөөний хувьд харьцангуй бага зүйл оруулж ирж байгаа гэдгийг хэлье ээ.

Д.Цогтбаатар: Тэгье. Мөнх-Оргил сайд нэг санал хэлье. Яг өөрөө сая хариулчихлаа л даа. Бусад улстай харьцуулахад зөөлдөөд байна. Би тэгэхлээр хэдүүлээ энийг нөгөө хэтэрхий ассиметртэй байна. Наадхыгаа тэнцвэржүүлээч гэсэн чинь нөгөө арга хэмжээ чинь хэт зөөлдөөд ороод ирчихсэн юм биш биз дээ. Энэ чинь чанга байх ёстой байхгүй юу. Тэгэхээр сүүлдээ арга хэмжээ авсан нэртэй өнөөдрийн төлөгдөөгүй байгаа. Энэ жишээлбэл хууль гараад л уг нь төлөгдөж эхлэх ёстой байхгүй юу. Тэр хүмүүс яг мэдрээд эхлэх ёстой тийм арга хэмжээ байна уу. Мөнх-Оргил сайдын саналыг сонсьё. Мөнх-Оргил сайдын микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Мөнх-Эрдэнэ зөвлөх өө, та нар сая тэр гаднын жишээ яриад байна шүү дээ. Тэндээсээ л ийшээ оруулаад ирэх ёстой байсан байхгүй юу. Эхнээсээ. Тэр баривчилдаг, эсвэл торгодог, эсвэл албадан ажил хийлгэдэг, эсвэл эд хөрөнгийг нь хураадаг. Тэгэхгүй төрийн албаны шалгалт өгүүлэхгүй, тендерт оролцуулахгүй, гадаад паспорт өгөхгүй гэхээр чинь энэ таны саяын хэлээд байгаа шиг 50, 60 удаа торгуулиа төлөөгүй хүмүүс чинь хэзээ ч тендерт орохооргүй хүмүүс л байхгүй юу. Хэзээ ч төрийн албаны шалгалтад орохооргүй хүмүүс байхгүй юу тэд нар чинь. Тэд нарт бол энэ чинь ерөөсөө үйлчлэхгүй. Харин ёстой сая Цогтбаатар даргын хэлж байгаа шиг мэдээгүй явж байгаад торгуулснаа мэдээгүй, камераа торгочихсон тэрийг нь мэдээгүй явж байгаад торгуультайгаа хараа ч үгүй явж байгаад гадаад паспорт авах гэсэн чинь өө та гадаад паспорт авах эрхгүй гээд тэд нар чинь хохироод үлдэх байхгүй юу. Тэгэхээр би бол ийм саналтай байгаа юм гишүүддээ. Энийгээ хэдүүлээ яг энэ ажлын хэсгийн саналаар дэмжээд явуулчихъя. Тэгэхдээ 2 дугаар хэлэлцүүлэг дээр саяын Мөнх-Эрдэнэ зөвлөхийн хэлээд байгаа тэр нэг бусад орнуудын туршлагауд байна шүү дээ 4 удаа төлөөгүй, 5 удаа төлөөгүй эсвэл 30 хоногийн дотор төлөөгүй, эсвэл нөгөө

хугацаа нь өнгөрчхөөд байдаг. Тэгэхэд нь дараагийн албадлагын арга хэмжээнүүд нь автомат орж байдаг тэр зохицуулалтыг л хийгээд өгчихье. Тэгэхдээ тэр гадаад паспорттай огт хамаагүй. Тэр машинтайгаа л ноцолдох хэрэгтэй. Машиныхаа эрхтэй, эсвэл өмч хөрөнгөтэй нь л ноцолдъё. Эсвэл жолоодох эрхтэй ноцолдъё. Тэгвэл арай ойлгомжтой болж байгаа байхгүй юу.

Д.Цогтбаатар: Яах вэ 2 дугаар хэлэлцүүлэг дээрээ хийх боломж байгаа юм чинь энэ дээрээ хэдүүлээ саналаа хураагаад явчихъя. Сэргэлэн гишүүн үг хэлье.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би яг энэ 8 дугаар зүйл дээр 1 санал байна. Энэ арай л бүртгэлтэй холбоотой нэлээн олон зөрчлүүд гараад байгаа юм. Жишээлбэл хүн андуураад торгуулийн мэдэгдэл ирээд байгаа юм. Өөрөөр хэлбэл надад би зөрчил гаргаагүй, миний эзэмидэг тээврийн хэрэгслийн дугаар биш шал өөр мэдээлэл ирээд байдаг. Утсанд. Та тийм зөрчил гаргажээ. Тийм учраас таныг торгоно ч гэдэг юм уу. Гэтэл үүний цаана жинхэнэ нөгөө зөрчил гаргасан хүн чинь тэрийгээ мэдээгүй явж байдаг. Өөрөөр хэлбэл торгосон тухай мэдээллийг Цогтбаатар даргыг таны хэлдэгтэй адилхан өөр хүнд мэдээлэл нь яваад өгсөн. Тэгэхээр нөгөө мэдээгүй хүн чинь яг хариуцлага тооцох болохлоор өөрөө хохирно шүү дээ. Яг сая Мөнх-Оргил гишүүний хэлдэгтэй адилхан. Тийм учраас мэдээллийн тэр систем, бас нэг ийм хувилбар байж байгаа юм. Таны эзэмшиж байгаа тээврийн хэрэгсэл гээд тээврийн хэрэгсэл эзэмидэггүй ч, тухайн тээврийн хэрэгслийг эзэмидэггүй ч гэсэн жолоо барьсан хүн дээр нь торгууль нь ирэхгүй. Тээврийн хэрэгслийн эзэмшигч дээр торгуулийн тухай мэдээллээр хүрээд ирдэг ийм л систем үйлчлээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дунд чинь хүн хохирох асуудал энэ дунд гарна гэдгийг л би хэлэх гээд байгаа юм. Тийм учраас энийг 2 дугаар хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг дээр нэлээн сайн

нарийн ярих зайлиггүй шаардлагатай байна л гэж би хэлэх гээд байгаа юм. Хүн хэлмэгдэх вий үүний цаана.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүн асуу асуу. Нэгэнт ярьж байгаа юм чинь наадхаа яриад байгаа юм.

Д.Ганбат: Хэдүүлээ ингээд бас цаг гаргаад хууль тогтоох гээд сууж байна л даа. Тэгэхээр энэ ажлаа үр дүнтэй болгохын тулд асуугаад, ярилцаад саналаа гаргаад явах нь зөв байх. Манай Байнгын хорооны дарга бол зөв шийдэж байна гэж ойлгож байна. Амартүвшин гишүүний оруулж ирж байгаа саналыг бол дэмжээд байна. Нэгэнт торгууль, янз бүрийн арга хэмжээ авдаг тэр нь биелэгддэггүй бол дараагийн юмаа ярих хэцүү шүү дээ. Тэгээд энэ ажлын хэсэг энэ мэргэжилтнүүд судалсан юм байгаа юу. Ер нь яагаад тэр торгууль тэр юм хумаа төлдөггүй юм бол. Тэр дээр судалгаа энэ тэр ч юм уу ийм учраас төлөхгүй байна. Ийм арга хэмжээ авбал зөв юм гэж. Хүмүүс амьдрал ахуй нь ядуу байна уу, ядруу байна уу. Эсвэл хэн нэгэн улс төрчид сонгууль болохоор бүгдээрээ энэ торгуулиас нь чөлөөлчихдөг үү. Ер нь байнга тийм юм явдаг л даа. Угаасаа энэ торгуулийн арга хэмжээг тэгж байгаад байхгүй болгочих юм чинь бид нар төлөхгүй байхад яадаг юм бэ гэсэн тийм бодол хүмүүс байна уу. Төлөөд байгаа хүмүүс нь тэгээд хохирдог. Тэгээд энэ хуулийг биелүүлдэг иргэд маань биелүүлээд явчихдаг. Биелүүлэхгүй байж байгаад нөгөө ер нь тиймэрхүү юм эрх баригчдаас л их гардаг л даа. Одоо би ингээд л ярихаар. Тэгэхээр ийм байна. Нөгөө талаар бол энэ торгуулийн тээврийн хэрэгслийг унаж оролцох тэр тээврийн хэрэгслийг нь хөдөлгөөнд оролцуулахгүй байвал яадаг юм бэ. Тээврийн хэрэгслийг нь хөдөлгөөнд оролцуулахгүй хориод ингэж явсан нь дээр байх. Тэгэхгүй бол хүмүүсийн амьдрал ахуй хүнд хэцүү байна. Тэгээд би яривал зөндөө л юм ярина л даа. Одоо болихоос доо.

Д.Цогтбаатар: Тэгэхээр ингэе. Ер нь ажлын хэсэг энэ дээр нээрээ анхаарах зүйл бий. Яагаад гэвэл түрүүний хэлэлцүүлэг дээр нэлээн ярьсан. Мэдээж яг ингээд байгаа оноогүй маягийн арга хэмжээнүүд байна гээд ярьсан. Гэхдээ зөвлө гэж яриагүй шүү дээ. Ер нь бол хууль санаачлагчийн бодлого чинь чангаруулах гэж орж ирсэн. Тэгэхээр чанга дээрээ л байна. Зөвхөн арга хэмжээгээ тэгэхээр илүү оновчтой болгох, энийгээ хэдүүлээ бодъё. Өөр санал оруулах боломж аягүй хязгаарлагдмал болж байгаа ч гэсэн бас боломж бий шүү. Тэгэхээр тэр дээрээ Мөнх-Эрдэнэ зөвлөх ажиллаарай. Ажлын хэсгийн дарга бас тэрийгээ анхаараад үзээрэй л гэж хэлмээр байна. Тэгээд энэ дээрээ тэгвэл санал хураагаад явчихъя.

Энэ түрүүний уншсан томьёоллоор дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Мөнх-Оргил гишүүн санал гаргах уу. Энэ юу чинь уначихлаа. Мөнх-Оргил гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнх-Оргил: Уучлаарай. Энэ кноп сая ажилласангүй. Та саяын саналыг хүчингүйд тооцоод, дахиж санал хураалгах горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүйд тооцохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 64 хувиар энэ санал дэмжигдлээ.

Ингээд түрүүн уншиж танилцуулсан томьёоллыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 71 хувиар саяын санал дэмжигдлээ.

Ингээд би түрүүн нөгөө Эрүүгийн хууль дээр орхичихсон 2 зүйлээр хэлэлцүүлэг явуулаадахъя.

Эрүүгийн хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Тэгвэл энэ 5 дугаар зүйлээр асуулт асууж, хариулт аваад дууслаа.

Ингээд хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ингээд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Зөрчлийн хуулийнхаа сая энэ чинь юу зарчмын зөрүүтэй 2 санал байсан. Би 1 дэх саналаар нь санал хураалт явуулчихсан. Ингээд 2 дахь саналыг нь уншиж танилцуулъя.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх үндэслэл нь энэ хуулийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.18, 5.20, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.17, 6.18, 6.20, 6.22, 6.23, 6.26, 6.27 дугаар зүйл, Долдугаар бүлэг, 8.1, 8.6, 8.7, 8.8, 8.9, 9.7, 10.3, 10.7, 10.15, 10.25 дугаар зүйл, Арван нэгдүгээр бүлэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.6, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13 дугаар зүйл, Арван тав, Арван зургадугаар бүлэг, 17.1 дүгээр зүйлд тус тус заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаарахгүй.” гэсэн томъёолол байна.

Ингээд энүүгээр асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Асуулт асуух гишүүн алга байна. Ингэхээр саяын уншсан томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар

санал хураалт явуулж эхэлье. Нэг саналтай байгаа.

3.Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Үүгээр асуулт асуух гишүүд байхгүй. Ингээд санал хураалт явуулъя. 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд алга.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье.

4. 4.Төслийн 5 дугаар зүйлийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон шилжүүлэх.

“3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“5.Жолооч:

5.1.согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.3.согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж, долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэсэн байгаа. Энэ 5.3 дээр зарчмын зөрүүтэй санал гишүүд гаргасан байгаа. Бямбацогт гишүүнд микрофоныг нь өгье.

С.Бямбацогт: Энэ 5.3 дээр арай л жсоохон хатуу болчихоод байх шиг

санагдаж байгаа. Сogтуурсан мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол мэдээж жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасна. Тэгээд шууд баривчилна гэж байгаа юм л даа. Сogтуу машин барьсныхаа төлөө торгуулна, дээрээс нь эрхээ хасуулна, мэдээж хэрвээ cогтуу машин барьж байгаад хэрэг зөрчил гаргах юм бол бас хуулийн дагуу хариуцлагын нэмэлтээр бас хүлээнэ. Тийм болохоор юу гэдэг юм cогтуу машин барьсан нөхрийг шууд л баривчлаад байвал бас арай л жоохон хүнддэх юм болов уу. Тийм болохоор эхний ээлжид торгоё. Давтаад cогтуу машин барих юм бол жинхэнэ баривчилъя гэдэг агуулгаар бас ингээд хүндрүүлж үзье. Тэгэхгүй бол хүн болгоныг шууд л cогтуу машин барилаа гээд баривчлаад байвал тэгээд арай л жоохон хатуудах юм биш үү гэдэг агуулгаар бид нар cогтуу машин барих юм бол жолоодох эрхийг нь 1 жилийн хугацаагаар хасаад, дээрээс нь 400 мянган төгрөгөөр торгоод, эсвэл 7-30 хоногийн хугацаатай баривчилъя гэдэг байдлаар жоохон бас уян хатан болгосон зохицуулалтыг л оруулж байгаа юм. Мөнх-Оргил гишүүн бид 2-оос гаргасан санал. Манай гишүүд бас тийм жоохон уян хатан байдлаар л гэсэн санал гаргаж байгаа юм.

Д.Цогтбаатар: Асууж болно. Энэ зарчмын зөрүүтэй санал юм чинь. Тэгэхдээ яг энэ зарчмын зөрүүтэй саналаар асуух гэж байгаа юм байгаа биз дээ тээ. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Мэдээж хэрэг энэ чинь нэг ёсондоо юу шүү дээ. Сogтууруулах ундаа, мансуурах бодис хэрэглээд ингээд явж байгаа хүмүүс чинь бас нөгөө хүмүүсийг бас хамгаалж байгаа ийм асуудал тийм ээ. Нөгөө талдаа бас зорчигчдыг бас хамгаалж байгаа. Аль аль талыг нь хамгаалсан л ийм л асуудал. Нөгөө хүмүүс маань давраад бүр гэмт хэрэгт орох юм байвал хууль тогтоогчид бид нар тэр замыг нь тавьчихсан юм шиг

болно. Тэгэхээр шат дараатай байх нь зөв. Саяын 2 гишүүний гаргасан саналыг бол үндсэндээ дэмжиж байна. Амьдрал дээр бол нөгөө шүүгч нь тэр тухайн нөхцөл байдлыг нь хараад эсвэл эрхийг нь бол тэртээ тэргүй хурааж таарна тийм үү? Машин барьж байгаа эрхийг хураана. Тэр 2 дахь дагалдсан заалт байна шүү дээ. Нэг нь бол торгох юм байна. Тухайн нөхцөл байдлаасаа шалтгаалаад эсвэл баривчлах юм байна. Энэ 2 заалтын эхний шатад хэрэглээд тэрний дараагийн шатны 2 дахь шат бол гэмт хэрэг гэж үзээд хорих юм байна. Энэ бол бас нэлээн зөв оновчтой болчихлоо гэж бодож байна. Энийг нь бол дэмжиж байна. Тэгээд яаж ийм мэргэн ухаан та 2-т төрөв.

Д.Цогтбаатар: Манайхан би байна шүү дээ. Энэ түрүүн 5 гээд жолооч гээд 5.1, 5.2-ыг бол уншаад танилцуулчихсан. 5.3 дээр шинэчилж найруулж оруулж байгаа саналыг би шууд уншаад танилцуулчихъя. Тэгээд энэ уншиж танилцуулснаар саналаа хураагаад явчихъя шууд. Саяын энэ уншиж танилцуулсан юуг бол ажлын хэсгийн санал гээд тэгээд би бүтнээр нь ер нь юу маргаангүй байх үүднээсээ бол шууд уншаад явчихъя тэгэх үү.

5.3-аа тэгвэл уншаад 5.1, 5.2 нь хэвээрэй. 5.3 нь ажлын хэсгийн санал.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын 4 дэх саналын 5.3 дахь заалтын хасаж гэсний дараа 400 мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл гэж нэмэх гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Энд уншиж танилцуулсан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 76 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зөрчлийн хуультай холбогдсон 2 дугаар зүйлийг би орхиод явчихсан байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төсөл хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя. 1 саналтай байгаа.

1.Төслийн 3 дугаар зүйлийн “1.2, 1.3, 1.4 дэх заалтын дугаарыг “1.3, 1.4, 1.5;” гэснийг “1.2., 1.3. дахь заалтын дугаарыг “1.3., 1.4.”” гэж өөрчилж, мөн зүйлийн “3.5-3.8 дугаар зүйлийн дугаарыг “3.7-3.10” гэж,” гэснийг “14.7 дугаар” гэсний өмнө шилжүүлэх. Энэ томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор. 84 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа оръё. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя. Нэг санал байгаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “агуулга бүхий зүйл, хэсэг” гэснийг

“агуулгатай дараах зүйл, хэсэг” гэж өөрчилж, 3 дахь заалтын 3 дахь хэсгийн “саналаа” гэсний дараа “оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил гаргасан харьяаллын” гэж нэмэх. Энэ томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн санал байхгүй байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя. 1 саналтай байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 41.2 дахь хэсгийн “10.1 дүгээр зүйлийн” гэсний дараах “2,” гэснийг хасаж, мөн зүйлийн 12.1 дүгээр зүйлийн “5 дахь” гэснийг “4 дэх” гэж, 4 дүгээр зүйлийн “2024 оны ... дүгээр/дугаар сарын ...-ны” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний” гэж тус тус өөрчлөх. Энэ томъёоллоор дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 84 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулна.

17.52 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас боловсруулсан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлүүлэхээр Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна. Гэр бүлийн тухай хууль нь хувийн эрх зүйн буюу иргэний эрх зүйн харилцааг зохицуулж байгаа суурь хуулиудын нэг юм.

Монгол Улсын хувьд хууль батлагдаж байсан үе буюу 1999 оноос хойш гэрлэх, гэрлэлт цуцлах, хүүхдийн эрх, хууль ёсны эрх ашиг, хөндөгдөх, зөрчигдөх, сэргээх зэрэг харилцаа ихсэж байгаа бөгөөд үүнээс үүсэх үр дагаврыг төдийлөн нарийвчлан зохицуулаагүй байна.

Тухайлбал, Монгол Улсад гэр бүлийн маргааныг оновчтой шийдвэрлэх гэр бүлийн гишүүдийн эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал нэн чухал болоод байна. Шүүхийн шийдвэрийн тоо баримтаас үзвэл 2020 онд 53,678, 2021 оны эхний хагаст 20,602 иргэний хэрэг шийдвэрлэснээс Гэр бүлийн тухай хуулиар 2020 онд 4732, 2021 оны эхний хагаст 2085 хэрэг шийдвэрлэсэн нь нийт хэргийн 10 хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд энэ төрлийн маргааны тоо ихсэх хандлагатай байна. Мөн олон улсын жишигээс үзэхэд гэр бүлийн харилцаанд шинэ төрлийн харилцаа асуудлууд нэмэгдэж байна.

Иймээс Гэр бүлийн тухай хуулийг олон улсын жишигт нийцүүлэх, шинээр үүсэж байгаа харилцааг зохицуулах, орхигдсон буюу хийдлийг арилгах зорилгоор тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Ингэхдээ хүүхэд жирэмсэн болон хөхүүл эмэгтэй эс үгүй бол бага насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх,

хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчмыг баримталаа. Түүнчлэн хуулийн төсөлд эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалахад илүүтэй анхаарч боловсруулсан.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгалаа. Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор садан төрлийн хүмүүсийн хоорондын гэрлэлтийг хориглож ДНК-ийн лавлагааг шинжилгээнд хамрагдах боломжийг төсөлд тусгалаа. 2014-2022 оны хооронд эцэг эх нь гэрлэлтээ бүртгүүлээгүй буюу хамтран амьдарч байх хугацаанд 22924 хүүхэд шинээр мэндэлсэн байна. Энэхүү тоо баримтаас үзэхэд хамтран амьдрах хэлбэр түгээмэл болсон байна. Манай улсын хувьд гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтран амьдарч байгаа хүмүүсийн эрхийг тодорхойлох, цаашилаад эд хөрөнгө хуваах, хүүхэд тэжээн тэтгэх асрамжлалын маргаан үүсэх тохиолдолд үүсэх хууль зүйн үр дагаврыг зохицуулах зохицуулалт байхгүй байна. Иймд хуулийн төсөлд хамтран амьдрагчийг тодорхойлж, тэдгээрийн хамтын амьдралын явцад болон хамтын амьдрал дуусгавар болох тохиолдолд эдлэх эрх, хүлээх үүрэг мөн ийм харилцаанаас төрсөн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалтыг тусгалаа.

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2022 онд шийдвэрлэсэн гэрэл цуцалсан шүүхийн шийдвэрүүдээс мөн 50 шийдвэрийг түүвэрлэн авч үзэхэд гэрлэлт цуцлах болсон шалтгаанд таарамжгүй харилцаа 76%, Архидалт 12%, тусдаа амьдарч байгаа 8%, гэр бүлээс гадуурх харилцаа 2%, гэр бүлийн хүчирхийлэл 2%-ийг тус тус эзэлж байна. Гэрэл цуцлах шалтгааны

дийлэнхийг гэрлэгч хоорондын таагүй харилцаа эзэлж байна.

Хуулийн төслөөр гэрлэгчдийн эрх, үүргийг нарийвчилсан бөгөөд үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талын эрх, нэр төр, алдар хүндэд хохирол учруулсан тохиолдолд иргэний хуульд заасны дагуу гэм хорын хохирол төлүүлэх нэхэмжлэл шүүхэд гаргаж болохоор зохицууллаа. Гэрлэлтийн гэрээ нь гэрлэгчид тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ноогдох эд хөрөнгийг тодорхойлох, эд хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөлийг иргэний хуульд нийцүүлэн байгуулах иргэний эрх зүйн гэрээ юм. Нөгөө талаар Англи Саксоны эрх зүйн бүлтэй зарим улсад гэрлэлтийн гэрээгээр эд хөрөнгийн харилцааг зохицуулахаас гадна мөн амины харилцааг зохицуулж байгаа жишиг ч байна. Гэрлэлтийн гэрээг БНСУ, Япон, ОХУ, ХБНГУ зэрэг улсууд хууль тогтоомжоороо зохицуулж байна. Иймд хуулийн төсөлд гэрлэлтийн гэрээний талаар шинэ зохицуулалтыг тусгасан бөгөөд тус гэрээгээр гэрлэгчдийн эрх ашгаа хамгаалах, гэр бүлийн харилцаанд мөн гэрлэлт цуцалсан тохиолдолд эд хөрөнгийн эрхээ хамгаалах боломжийг бий болголоо. Мөн гэрлэгчид гэрлэлтийн гэрээгээр эд хөрөнгийн эрх үүсэх, шилжүүлэх, дуусгавар болгох, хязгаарлахаар зохицуулсан эсхүл ийм харилцаа агуулсан бол зохих журмын дагуу хөрөнгийн бүртгэлээс хамаарч бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх зохицуулалтыг нэмж тусгасан. Ингэснээр гэрлэгчдийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах нөхцөл бүрдэнэ гэж үзлээ.

2017-2021 онд Гэр бүлийн хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн хэргийн 60,4 хувь буюу 14 мянган хэрэг гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг шийдвэрлэсэн байна. Мөн 2010 онд гэрлэлт цуцалсан тоог 2021 онтой харьцуулахад 10 гаруй хувиар өссөн байна. Иймд гэрлэлт цуцлах үед гэрлэгчид болон хүүхдийн эрх ашгийг

хамгаалах зохицуулалтыг нарийвчилж тусгалаа.

Хуулийн төсөлд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг хариуцлагыг нарийвчилсан бөгөөд хүүхдээс тусдаа амьдарч байгаа эсэхээс үл хамааран хүүхдийн өмнө хүлээх эцэг эхийн үүрэг, хариуцлагыг хамтран хүлээх зарчмыг тодорхой зохицууллаа. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхдийн эд хөрөнгийн хүүхдийн хэрэгцээнд зарцуулах зохицуулалтыг ч тусгалаа. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлж байгаа гэр бүлийн харилцаа байхыг энэ хуулиар хүлээн зөвшөөрч, уг харилцааг гэрээгээр зохицуулах, асран хамгаалалт харгалзан дэмжлэгт байгаа хүүхдийн эд хөрөнгийг зарцуулах, хамгаалах, тэтгэмж, тэтгэлэг, түүнтэй адилтгах орлогыг зарцуулалтад хяналт тавих зэргийг тусгалаа.

Түүнчлэн хүүхдийн эд хөрөнгийн эрхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зарцуулах эрхийн хязгаарлалтыг зохицуулсан. Манай улсын хувьд тэтгүүлэгч буюу хүүхдийн амьдарч байгаа бүс нутагт тогтоосон амьжиргааны доод түвшний хэмжээнээс тодорхой хувиар тооцсон тэтгэлгийн хэмжээг тогтоож байна. Иргэд олон нийтийн зүгээс хүүхдийн тэтгэлгийн хэмжээ хэт бага буюу хүүхдийн хэрэгцээнд хүрэлцэхгүй байх, нөгөө талаас тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдахгүй байна гэсэн шүүмж гардаг. Зарим улсад тэтгэлэг тогтоох тусгай аргачлалтай бөгөөд тэтгэлгийн хэмжээг хүүхдийн нас амьжиргааны өртөг зардал зэрэг хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан тэтгэлэг төлөгчийн орлого нөхцөл байдалтай уялдуулж тэтгэлэг авагч тус бүрд өөр өөр байдлаар тогтоож байна. Хүүхдийн тэтгэлгийн харилцааг зохицуулсан гэрээ байгуулж болохоор зохицуулсан байна. Иймд шүүх гэрлэлт цуцлах шийдвэрийг гаргахдаа нэхэмжлэлийн шаардлагад дурдсан эсэхээс үл хамаарч, хүүхдийн тэтгэлгийн

асуудлыг заавал хамтад нь шийдвэрлэхээр зохицууллаа. Мөн гэрлэлт цуцлалт дуусгавар болсон харилцаанд хүүхэд болон гэр бүлийн гишүүдийн авах тэтгэлгийн хэмжээг өөрчилж, тэтгэлэг авагч болон тэтгэлэг төлөгчийн нөхцөл байдалтай уялдуулж эрх бүхий байгууллагаас батлах аргачлалын дагуу шүүх шийдвэрлэхээр шинэ зохицуулалтыг тусгалаа.

Хүүхдийн тэтгэлгийг шийдвэр, шүүхийн шийдвэр, гүйцэтгэлийн мэдээллээс үзэхэд 50 гаруй хувь нь огт төлөгддөггүй байна. Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тэтгэлэг авагч нийт 13,866 хүүхэд байгаагаас 9,739 хүүхэд тэтгэлгээ авч чадаагүй ба тэтгэлгийн хэмжээгээр нь тооцож авч үзэх юм бол 6 тэрбум 606 сая төгрөг төлөгдөөгүй байна. Иргэний бүртгэлийн байгууллагын мэдээллээр 2017-2022 оны 3 дугаар сар хүртэл хугацаанд 7,596 хүүхэд дотоодод үрчлүүлсэн бол Монгол Улсын харьяат нийт 274 хүүхэд гадаадын иргэдэд үрчлэгдсэн байна.

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцсон 2017-2021 оны шүүхийн шийдвэрийг авч үзэхэд 2017 онд 97 шүүхийн шийдвэр, 2018 онд 12 шүүхийн шийдвэр, 2019 онд 11 шүүхийн шийдвэр, 2020 онд 12 шүүхийн шийдвэр, 2021 онд 9 шүүхийн шийдвэр байна. Иймд хуулийн төсөлд хүүхдийн эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үрчлүүлэх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэх шинэ зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төслийн үзэл баримтлал хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Солонгоо, Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Жамьянхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн шинжээч Цолмон, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Баярмаа, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Батчулуун, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга хурандаа Оюунцэцэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Банк, хадгаламж, зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны дэд дарга, хошууч Базарсад, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Төгөлдөр, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Наранцэцэг, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Өлзийхутаг, Олон Улсын Улаанбаатарын Их сургуулийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн доктор Амарсанаа, Монголын Хуульчдын Холбооны гишүүн, хуульч Ичинхорлоо, Гадаадын иргэн харьяатын газрын Иргэний харьяаллын газрын мэргэжилтэн Бат-Ундрах нар оролцож байна.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Сандаг-Очир гишүүнээр асуулт асуух гишүүдийг тасаллаа. Ингээд Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Баярлалаа. Хууль санаачлагчаас хэдэн асуулт асууя. Гэрлэлтээ цуцлуулахад заавал шүүхээр орох уу. Өөрөөр хэлбэл 2 тал нь харилцан зөвшилцөөд ямар нэгэн эд хөрөнгийн

маргаангүй, хүүхдийнхээ асрамжийн асуудлаа шийдсэн ийм тохиолдолд барууны зарим улс орнуудад бол заавал шүүхээр орохгүйгээр гэрлэлтээ цуцлуулах тийм боломж байдаг. Тэгэхээр энэ оруулж ирж байгаа хуулийн төслөөр ийм боломж байх уц, үгүй юү. 1 дүгээрт.

2 дугаарт үнэхээр гэрлэлтээ цуцлуулахад хүрээд ямар нэгэн байдлаар шүүхээр орох юм бол тэр шүүх хурал нь онцгой шүүх байх уу. Бид нар жишээлбэл өмнө нь Нямбаатар сайдтай Их Британийн гэр бүлийн шүүхтэй танилцсан л даа. Тэр дээр бол яг ийм хэргийг шийдвэрлэдэг ийм тусгай шүүхтэй байдаг юм байна лээ. Зүгээр манайд тийм практик байхгүй гэж ойлгож байгаа. Яагаад энийг асуугаад байна гэхээр мэдээж хэрэг гэрлэлтээ цуцлуулах бол эмзэг асуудал. Энийг бол хүн болгон ингээд л зарлаад байдаггүй. Тэгэхээр энэ 2 талын бас хувь хүний нууцлалыг хангадаг, олон түмэнд зарлахгүй шүүх хурал нь явдаг. Яагаад гэвэл энэ чинь бас гэр бүл, хүүхдүүдэд нь бас тодорхой хэмжээгээр нөлөөлдөг учир энэ дээр аягүй тийм мэдрэмжтэй эмзэг асуудал болохоор мэдрэмжтэй ханддаг юм байна лээ л дээ. Тэгэхээр энэ хуулийн төсөлд тийм зохицуулалт байна уу, үгүй юү гэдгийг би тодруулж асууя.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ. Солонгоо сайд 5 дугаар микрофон өгье.

Б.Солонгоо: Та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе. Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 12 дугаар зүйл дээр гэрлэлтийг захиргааны журмаар цуцлах гэсэн заалт байгаа. Тэгээд энд бол тодорхой нөхцөлүүд тусгаад, тэгээд Улсын бүртгэлийн байгууллага болон Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар тодорхой хуулийн шаардлага хангасан нөхцөлд бас захиргааны журмаар гэрлэлтийг цуцлах боломж байгаа. Тэгээд үндсэн тавигдаж байгаа шаардлага нь 1 дүгээрт 18 нас

хүрсэн хүүхэдгүй байх, тэгээд эд хөрөнгийн аливаа маргаангүй байх, тэгээд бичгээр энэ талаар гэрлэгчид бас хүсэлт өгсөн тохиолдолд захиргааны журмаар бол цуцлах боломж байгаа. Хэрвээ 18 нас хүртэлх хүүхэдтэй бол ер нь шүүхийн журмаар гэр бүл цуцлахаар байгаа. Тэгээд ер нь бол гол асуудал нь гэр бүл цуцлахад хөндөгддөг томоохон асуудал нь хүүхдийн эрх ашиг байдаг. Бидний хувьд тодорхой нөхцөлүүдэд 3 нас хүртэлх хүүхэдтэй эх болон тодорхой нөхцөлтэй байгаа. Тухайлбал хүнд өвчтэй байгаа ч юм уу, тэр тохиолдолд гэр бүл цуцлах нэхэмжлэлийг шүүхээс шийдвэрлэхгүй байхаар нөхцөлүүдийг тусгасан. Энэ бас гол зорилго нь хүүхдийн эрх ашгийг хамгаалах, мөн тухайн гэрлэлтэд илүү сул тал болж байгаа гэрлэгч талыг хамгаалах зорилготой. Ер нь бол захиргааны журмаар гэрлэлт цуцлахаас бусад тохиолдолд гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг шүүхээр шийдвэрлэхээр байгаа. Тэгээд бид нар бас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулаад Дээд шүүхийн шүүгчид, давж заалдах шатны шүүх болон анхан шатны шүүхийн шүүгчидтэй энэ талаар бас хэлэлцүүлгүүд зохион байгуулсан. Тэгээд ер нь бол цаашидаа манай улсад гэр бүл, хүүхдийн асуудлаар дагнасан шүүх байгуулах цаг нь болсон байна гээд Хууль зүй, дотоод дүүргийн яам дээр Шүүх байгуулах тухай хуулийн төсөл бол боловсруулагдаж байна. Тэгэхээр цаашидаа бидний хувьд энэ чиглэлээр мэргэшсэн шүүх гэр бүлийн маргааныг шийдвэрлэдэг болох чиглэлээр ажлууд хийх нь зүйтэй юм байна гээд ажиллаж байна.

Яг өнөөдөр Чингэлтэй болон Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатын шүүх дээр гэр бүлийн маргааны чиглэлээр шүүгчид дагнаж бас хэрэг маргаан шийдвэрлэж байгаа туршлага, жишиг бол байна. Энэ нь цаашидаа гэр бүлийн маргааны онцлог шинжийг харгалзаж мөн хүүхдийн эрх

ашиг хөндөгддөг эмзэг асуудлууд байдаг учраас цаашидаа сэтгэл зүйч болон нийгмийн ажилтны оролцоог илүү өргөн хүрээтэй хангаж, гэр бүлийн маргааныг бол шийдвэрлэдэг болоход дөхөмтэй байна гэдэг байр суурийг шүүгчид илэрхийлж байгаа. Тэгээд энэ талаар бас үргэлжлүүлээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны яг иргэний процессын хууль дээр ч гэсэн холбогдох бас өөрчлөлтүүд ороод явах байх. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Мөнхцэцэг гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Гэр бүлийн хуулийн концепцыг бол дэмжиж байна. Гэр бүл салалт нэмэгдэж байгаа. Гэр бүлийн харилцаанд хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүдийн эрх ашиг зөрчигдөх явдал удаа дараа гарч байгаа учраас энэ эрх зүйн зохицуулалтыг, тэгээд хүүхдийн эрхийг хамгаалах энэ яг олон улсын чиг хандлагад нийцүүлэн өөрчилж байгаа нь үнэхээр дэвшилттэй байна. Тухайлан гэр бүл дэх эцэг эхийн үүргийг нарийвчлан зохицуулсан нь их сайшаалтай байгаа. Эндээс ингээд онцлоод харахаар төслийн 30.3.3 дээр энэ төрөлх хэл бичиг үсэг суурь боловсрол эзэмшүүлэх нь эцэг эхийн үүрэг болж зааж өгсөн байна. Тэгээд энэ бол үнэхээр чухал. Монгол эцэг эх хүүхдээ Монгол хэлээр өсгөх, дэлхийн хаана ч амьдарч байсан Монгол хэл, соёлыг эзэмшүүлэх нь эцэг эхийн үүрэг гэдэг бол үнэхээр чухал асуудал байгаа. Тэгээд энэ бол хүн ам цөөтэй Монгол улсын хувьд бол үндэсний дархлааны томоохон асуудал байгаа. Энийг ингээд гэр бүлийн хуульд оруулж байгаа нь их зүйтэй байна. Мөн гэр бүл цуцалсан тохиолдолд хүүхдийн эрхийг хамгаалах, хамтран амьдрагч болон эцэг эх нь тусдаа байсан ч гэсэн тухайн хүүхдийн хүмүүжүүлэх, шаардлагатай тэтгэлэг өгөх асуудлыг мөн эцэг эхэд нь үүрүүлж байгаа нь бас чухал зүйл байгаа. Тэгээд 3 асуулт байгаа.

Энэ төсөлд гэрлэгчдийн эрх үүргийг бол нарийвчлан зааж өгсөн.

Шаардлагатай бол гэр бүлийн гэрээ байгуулахаар хуульчилсан байгаад байна. Дээрээс нь ёс суртахууны үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талын эрх, нэр төр, алдар хүндэд хохирол учруулсан тохиолдолд иргэний хуульд заасны дагуу гэм хорын хохирол төлүүлэх нэхэмжлэл шүүхэд гаргаж болохоор зохицуулсан гэж байгаа юм. Энийг ер нь тодруулмаар байгаа юм. Өөрөөр хэлбэл нөгөө талын нэр төр, алдар хүндэд учруулсан хохирол гэдгийг нь бусад улсуудын жишгээр, жишээлбэл БНСУ-ын жишгээр энэ гэр бүлээс гадуурх харилцааны тохиолдол орж байгаа юу, үгүй юу. Тухайлбал нөгөө Солонгост бол гэр бүлээс гадуурх харилцааны улмаас гэрлэлтээ цуцалж байгаа тохиолдолд нөгөө буруутай этгээдэд мөнгөн төлбөр оногдуулдаг. Тэгэхээр энэ маань энэ утгаар явж байна уу, үгүй юу. Нөгөө талын эрх, нэр төр алдар хүндэд хохирол учруулсан гэдгийг юу гэж зохицуулсан бэ.

2 дугаар асуулт нь нөгөө садан төрлийн гэрлэлтийг хориглох, цус ойртолтоос сэргийлэх үүднээс яг гэрлэлтийг бүртгэх үед цус ойртолтоос хамгаалах ийм зохицуулалт хийсэн гэсэн байгаа. Тэгэхээр энийг бас тодруулж өгмөөр байна. Яг ямар зохицуулалт орж байгаа вэ.

Төслийн 24.2 дээр бол одоо үйлчилж байгаа Гэр бүлийн тухай хуулийн заалт бол давтагдаад явж байна л даа. Хүүхэд эцгийн овог нэрийг авна гэж. Тэгэхээр энэ маань яг олон улсын чиг хандлагаар явж байна уу, үгүй юу. Ер нь бол сүүлийн үед улс орнууд гэр бүлийн харилцаанд ялгаварлан үүсгэх, эцэг болон эхийн аль нэг овоглосон гэр бүлд өсөх, тэгээд овгийн нэрээс улбаатайгаар тухайн хүүхдийн тэнцвэртэй байдал алдагдах, жендерийн тэгш байдлыг хангах зэрэг үүднээс Итали, Энэтхэг зэрэг нэлээд олон улсын дээд шүүх бол хүүхэд эцэг эхийн алинаар нь ч овоглосон болно гэдэг энэ зохицуулалтуудыг оруулж ирээд байгаа. Тэгэхээр манай энэ хуулийн төсөл бол яг өнөөдөр байгаа

хууль шигээ л адилхан хүүхэд зөвхөн эцгийн овог нэрийг авахаар оруулж ирж байна л даа. Энийг яг олон улсын чиг хандлага руу шилжүүлэх, хэрвээ харилцан тохиролцсон тохиолдолд эцэг эхийн алийг нь ч овгийг авахаар оруулж болохгүй байсан уу. Ер нь жишээлбэл энэ Солонгос улсын Жендерийн эрх тэгш байдлыг хамгаалах яам бол өнөөгийн эцгээр овоглодог тогтолцоо нь гэрлээгүй юм уу, эсвэл өрх толгойлосон эцэг эх мэт янз бүрийн гэр бүлийн хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах явдалд хүргэж магадгүйн улмаас Хууль зүйн яамтайгаа зөвшилцөн энэ асуудлыг эцэг эхийн алинаар нь ч овоглож байхаар өөрчилнө гэдэг ийм мэдэгдлүүдийг хийгээд байгаа. Тэгэхээр энэ дээр тодруулах хэрэгтэй байна.

Д.Цогтбаатар: Солонгоо сайд 5 дугаар микрофон.

Б.Солонгоо: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Тэгээд бас ер нь бол манай иргэдийн зүгээс бид нар оролцогч талуудтай Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр хэлэлцүүлгүүд зохион байгуулахад бол үндсэн 3 асуудал хөндөгдөж байсан.

1 дүгээрт бол гэр бүлийн тогтвортой байдлыг хадгалах, хамгаалахад зохицуулалтууд шаардлагатай байна.

2 дугаарт гэр бүл цуцалсан тохиолдолд хүүхдийн тэтгэлгийг хүрэлцэхүйц хэмжээтэй байлгахад анхаарах.

3 дугаарт гэр бүл цуцлахад бас томоохон хүчин зүйл болоод байгаа гэр бүлээс гадуурх харилцааг бас зохицуулах шаардлагатай байна гээд иргэдийн зүгээс бол энэ 3 асуудал дээр их хүлээлттэй байгаа. Бидний хувьд бол энэ асуудлуудаар бас нэлээн судалгаанууд хийгдсэн, судлаачидтай хамтарч ажилласан. Тэгээд шүүхийн практик ч

гэсэн энэ чиглэлээр ямар байдалтай байна гээд шүүхэд байгуулахдаа ч гэсэн бас хэлэлцүүлгүүд зохион байгуулсан. Тэгээд яг таны бас дурдсан энэ гэм хор нэхэмжлэх асуудал маань яг гэр бүлээс гадуурх харилцаа үүсээд тэрнээс шалтгаалаад гэр бүл цуцалсан тохиолдолд гэрлэгчдийн аль нэгнийх нь бас нэр хүндэд гэм хор учирсан гэж үзэх юм бол шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг бол нээж өгч байгаа. Энэ бол Иргэний хуулийн суурь гэм хор нэхэмжлэх эрхтэй уялдаж, Иргэний хуулийн дагуу бол энэ асуудал яг шийдэгдэнэ. Гэхдээ яг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нэхэмжлэл гаргах эрхийг нь бол нээж өгсөн. Солонгос улсад яг таны бас сая дурдсан практик бол байдаг. Өнөөдөр Солонгос улсын шүүхийн практик хуульд ч гэсэн гэр бүлээс гадуур харилцаа үүсгээд хэн нэгэн буруутай нь тогтоогдох юм бол мөнгөн торгууль төлбөр төлдөг асуудал байна. Тэгээд үүнтэй холбогдуулаад Амарсанаа судлаач нэмэлт хариулт өгөх боломжтой.

Цус ойртолтоос урьдчилан сэргийлэхтэй холбогдуулаад энэ ДНК-ийн шинжилгээ өгдөг болох зохицуулалтыг хуульд бол оруулсан. Гэхдээ нөгөө талаасаа бид нар хүн амынхаа дунд ДНК-ийн шинжилгээний судалгааг нэлээн өргөн хүрээтэй хийж, мэдээллийн сантай болсны үндсэн дээр садан төрлийн холбоотой эсэхийг тогтоох ДНК-ийн шинжилгээний бодитой, яг үр дүн нарийвчлалтай сайн гарах боломжтой. Тэгэхээр Шүүх шинжилгээний ерөнхий газартаа бидний хувьд энэ талаар бас нэлээн сайн хэлэлцүүлгүүд зөвшилцлийг хийсэн. Тэгэхлээр бидний хувьд хууль хэрэгжүүлэх дээр хугацаа, шилжилтийн хугацаа хэрэгтэй байгаа. Тэгэхээр бэлтгэл ажлуудыг хийж, энэ ДНК-ийн шинжилгээ авдаг болох лаборатори, тэгээд үндсэн мэдээллийн сан бүрдсэний дараа энэ шинжилгээнд хамрагдаж болох бололцоо нээгдэж байгаа. Яг энэ хүүхэд эцгийн нэрээ авах эсэх асуудал

дээр бол хуулийн төслийг боловсруулах шатад болон эцэслэх хугацаанд оролцогч талуудтай хэлэлцүүлгүүдийг үе шаттай зохион байгуулсан. Тэгээд яг өмнө нь байсан 1999 оны Гэр бүлийн тухай хууль өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гэр бүлийн тухай хуулийн зохицуулалтыг бол өөрчлөөгүй. Өөрчлөөгүй үндсэн зорилго нь бол яг сая дурдсан цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, хэрвээ бас эхээрээ овоглоод эхлэх юм бол манай улс шиг хүн ам цөөтэй улсын хувьд цаашидаа цус ойртолт үүсэх, үндэсний манай уламжлалын дагуу эцгээрээ овоглохоо болиод эхлэхээр бас садан төрлийн холбоогоо мэдэхээ больчих эрсдэл үүснэ гэдэг асуудлыг бол ялангуяа манай шүүгчдийн зүгээс нэлээн гаргасан. Тийм учраас одоо байгаа зохицуулалт бол өөрчлөгдөөгүй. Энэ хэвээр нь үлдээсэн байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу. 7 дугаар микрофон.

О.Амарсанаа: Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе. Гишүүний асуултад хариулъя. Гэр бүлийн тухай хууль дээр гэр бүлээс гадуурх харилцаа өөрөө ёс зүйн асуудал юм уу, эрх зүйн асуудал юм уу гэдэг асуудал бас нийгэмд нэлээн яригддаг. Тэгэхдээ олон улсын туршилагыг харахаар нийгмийнхээ бас олон хөгжлийн үе шатуудад дамжаад эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан тохиолдлууд бол маш олон өндөр хөгжилтэй улсуудад байдаг. Эрүүгийн хариуцлага хүлээлгэж ирсэн эл орнуулыг хараад байхаар сүүлийн үед бол нийгмийн хөгжлийнхөө хүний эрхийн бас суурь эрхэд бол халдаж байна гэдэг үүднээс Эрүүгийн хууль тогтоомжоосоо бол энэ хариуцлагыг хассан байдаг. Тэгвэл энэ гэр бүлээс гадуур харь гадуурх харилцаа нь өөрөө гэрлэгчид бие биедээ үнэнч байхаас гадна гэр бүлийн хамтын амьдралыг тогтвортой байлгахад ямар үүрэгтэй юм бэ. Үүнд эрх зүйн хувьд ер нь ямар хариуцлага нөлөөлөл бий болгож болох вэ гэдэг асуудал тулгардаг. Тэгэхээр эрх

зүйн хариуцлага бол ерөнхийдөө хатуу чанга байх юм уу, эсвэл зайлиггүй байх юм уу гэдэг дээр яригдаж шийдэгддэг. Тэгээд энэ харилцаа нь бол ер нь зайлиггүй байх ёстой юм байна. Гэхдээ энэ нь нийгмийн нөлөөллийн талаасаа илүү харж үзвэл зүгээр юм биш үү гэдэг байдлаар томъёолсон. Тэгээд гэрлэгчдийн аль нэг маань гэр бүлээс гадуурх харилцаанд орсноор тэр нь гэр бүлийг цуцлагдах үндэслэл болсон гэж үзвэл Иргэний хуульд заасан эдийн бус гэм хорыг нэхэмжлэх боломжийг бол нээж өгсөн. Гэхдээ энэ дээр манай улсын туршлага бол шүүхийн практикт 1, 2 ийм шүүхийн шийдвэрүүд бас байдаг. Анхан шатын шүүхийн шийдвэрүүдээр бол ингэж шийдвэрлэж өгсөн. Энэ нь болохоор эдийн бус гэм хор гэдэг үнийн асуудлыг бол мэдээж явцдаа шүүх практикаараа тогтоогоод ингээд явах болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа. Гол юм нь өөрөө бол энэ гэр бүлийг зөвхөн тогтвортой байлгахад гадна гэр бүлээс гадуурх харилцаанаас болж гэр бүл тогтворгүй болсноос хүүхдийн эрх ашиг зөрчигддөг ийм том асуудал байдаг. Тэгээд энэ үүднээс нь бол бас зайлиггүй оруулж ирэх ёстой гэж үзсэн.

2 дугаарт энэ үйлдэл нь өөрөө буруутай этгээдийн үйлдэл нь нөгөө гэрлэгчдийнхээ эрхэд, гэр бүлээ тогтвортой байлгах эрхэд нь бол бас халдаж байгаа гэсэн ийм онолын тайлбар байгаа. Мөн гэрлэлт гэдэг бол нэг ёсондоо гэрээ буюу хэлцэл гэсэн ийм ойлголт байдаг. Тэгэхээр талууд бол энэ гэр бүлээ тогтвортой байлгах үүрэгтэй. Дээрээс нь хэлцлээр хүлээсэн үүрэг, хүсэл зоригоо илэрхийлэх энэ хэлцэлд буюу гэр бүлийн харилцаанд орж байгаа энэ үйлдэл бол өөрөө зайлиггүй бас тодорхой хэмжээний хариуцлага байх ёстой юм байна. Энэ хариуцлага нь хатуу чанга байхаасаа илүүтэйгээр нийгмийн нөлөөллийн мөнгөн дүн, нэхэмжлэлийг шаардах эрх нь бол мэдээж их биш байж болно. Бага байж болно. Гэхдээ тухайн хүний буруутай этгээдийн нийгэмд эзлэх байр суурь, цалин хөлс энэ бүхнээс

шалтгаалаад ялгамжтайгаар ингэж шүүх тогтоож нэхэмжлэлийг шийддэг ийм олон улсын практикууд байдаг. Тэгэхээр Иргэний хуулийн эдийн бус гэм хорын хүрээнд бол суурь зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой. Гэхдээ дээрээс нь энэ нэмэлт, өөрчлөлт дээр Иргэний хуулийнхаа эдийн бус гэм хорыг шийдвэрлэх, зохицуулах энэ зохицуулалтуудаа уялдуулахын тулд энэ эрх гэдэг агуулгыг илүү тодотгож томъёолох бас хэрэгцээ шаардлага байгаа гэсэн ийм хариулт хэлэх байна.

Д.Цогтбаатар: Мөнхцэцэг гишүүн хариулт авч болсон уу. Тэгвэл Учрал гишүүнд микрофон өгье.

Н.Учрал: Энэ гэр бүлийн хууль дээр анхных нь төсөл дээр бас саналаа өгсөн. Сүүлд манай яамнаас бас санал өгсөн. Тэгээд энэ хуульд бол энэ ураг төрлийн харилцаагаа тодруулж байж гэрлэх буюу Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг шийдэхээр оруулж ирж байгаа гэж үзэл баримтлал танилцуулга дээрээ дурдаж байгаа. Танилцуулгаас харахад бол манай улсын нутаг дэвсгэрт хүн амын 6,1 хувь нь цус ойртсон байх магадлалтай гэсэн судалгаа гарчээ гэсэн ийм танилцуулгатай. Ер нь энэ угийн бичиг хөтөлбө. Хүн амын удмын сангаа хамгаалъя гэдэг асуудал бол олон жил ингээд лоозон хэлбэртэй яригдаж байгаа. Өнгөрсөн Их Хурлын төсвийн үеэр байна уу даа. Их Хурлын тогтоол ч гарсан. Хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалахад нэгдсэн ийм системтэй болъё. Гэрлэхэд тухайн гэрлэж байгаа 2-ыг тэр хүн амын удмын сангийн аюулгүй байдлын системээр нь шалгаад, ямар нэгэн цус ойртсон зүйл байна уу, үгүй юу гэдгийг шалгачихдаг болъё гээд. Тэгээд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр ч гэсэн энэ асуудал яригдаад л энэ анхааруулга өгөөд л хэрэгжүүл л гээд байдаг. Өнөөдрийг хүртэл бол хууль, тогтоол, дүрэм, журам бол хангалттай байгаа. Энэ удаа ч гэсэн нэг ийм лоозон л оруулж ирж л байгаа л даа. Тэгээд яах

вэ, үүрэгжүүлээд. Гэрлэж байгаа 2 угийн бичиг хөтлөөрэй. Тэрийгээ өвлүүлээрэй л гэж хэлж байгаа юм байна. Тэгээд энийг хийхэд бол их хүндрэлтэй. Тэгээд би өнгөрсөн жилээс хойш энэ асуудал дээр онцгой анхаарч ажиллаж ирсэн. Ингээд Хууль зүйн яаман дээр Архивын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар хамтарч ажиллах хэрэгтэй байгаа юм. Хүн амын тэр нэгдсэн тооллого цаасан хэлбэрээр байгаа. Энийг бид нар цахимжуулж байж, тэгээд бүртгэлийн системтэй холбож байж нөгөө гэрлэлтээ бүртгүүлэх гээд ирээд ирж байгаа 2 хүнийг одоогийн бид нарын иргэний таньж байгаа системээр таньж байж, түүнд нь хариу дүгнэлт өгдөг байхгүй бол өнгө үзэмжээр үүнийг дүгнэх бололцоо угаасаа байхгүй. Тэр орчин үеийн дэвшилтэт технологи ашиглахаас өөр сонголт байхгүй. Тийм ч учраас олон улсад бүх төрлийн ийм угийн бичиг хөтлөх хамгийн сайн шилдэг системүүд гарчихсан байна шүү дээ. Heritage энэ тэр гээд. Монголд ч гэсэн аягүй олон старт ап компаниуд энийг хийчихсэн. Тэгээд энийг хуульд их тодорхой тусгахгүй бол энэ бол явахгүй ээ. Тийм учраас тэр төрийн үйлчилгээний үндсэн систем дээр интеграци хийж архивын тэр баримт материалд түшиглэж байж дээрээс нь Хууль зүйн сайд өөрөө тэр хүн амын нэгдсэн тооллогын тэр цахим тооллогыг нэгдсэн системд бүртгэлжүүлж байж ингээд бүртгэл өөрөө дэмжих систем хөгжүүлж байж энийг хийх юм байна лээ. Тэгээд энийг хийх нь өөрөө манай улсад бол өндөр ач холбогдолтой байгаа. Маши өндөр ач холбогдолтой. Тэгэхээр энэ их чухал асуудал учраас би шинээр томилогдсон Хууль зүйн сайдыг энэ архив, бүртгэл 2-ыг энэ угийн бичиг хөтлөх дээр ажиллуулаач ээ. Их анхаарч өг гэж сайн хэлээрэй. Тэгээд миний зүгээс бол манай яамны зүгээс бол бас ингээд дэмжлэг үзүүлээд ажиллахад бэлэн байна. Тэгэхгүй бол дахиад л нэг хуулийн заалт ордог, тэгээд яг амилахад бол хэцүү шүү. Тийм учраас Солонгоо сайд хариулчихна биз. Яг энэ хууль дээр

хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хангахад яаж шийдвэрлэх гээд байгаа юм. Яг яаж түүнийг тодорхойлох гээд байгаа юм. Эсвэл зүгээр л гэрлэж байгаа 2 дээр үүрэг дээр нь угийн бичиг хөтлөөрэй, өвлүүлээрэй гээд бичээд л яваад байгаа байхгүй юу. Тэгээд амьгүй л заалт болчих вий л гэж. Энийг чинь дагаад төсөв мөнгө ч бас яригдах л байх.

Э.Бат-Амгалан: Солонгоо сайд хариулах уу. 5 номерын микрофон өгье.

Б.Солонгоо: Баярлалаа. Учрал сайдын асуултад хариулъя. Ер нь бол энэ асуудал бас өмнө нь Улсын Их Хурал дээр яригдсан. 2022 оны 4 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлаас гарсан тус тогтоолоор тодорхой шийдвэрүүд гаргасан. Тэгээд ер нь бол энэ ДНК-ийн шинжилгээ бас бодитой, үнэн, зөв гардаг болоход бас нэлээн судалгааны сан мэдээллийн сан бүрдэх шаардлагатай юм байна лээ. Тэгэхлээр Шүүх шинжилгээний ерөнхий газар дээр бас энэ дээр бол үргэлжлүүлээд аймгуудын хувьд, бүс нутгуудын хувьд бас мэдээллийн сан бүрдүүлсний үндсэн дээр яг бодитойгоор энэ шинжилгээний үр дүн бас бодитой гарах асуудал яригдана гээд шилжилтийн үеийн зохицуулалтыг бас хуульд оруулах саналыг бол гаргаж байгаа.

Угийн бичиг хөтлөх дээр бол гэрлэгчдийг үүрэгжүүлсэн заалтыг бол тусгасан. Гэр бүл гэрлэлт хүчин төгөлдөр байх асуудал дээр бас төрөл садангийн холбоотой бол гэрлэлтийг хүчингүйд тооцох, шүүхэд нэхэмжлэл гаргах боломжийг олгосон байгаа. Тэгээд цаашидаа бол энэ хуульд тусгасан заалтыг хэрэгжүүлэх дээр төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа бас зайлигүй шаардлагатай гэдэг дээр бол санал нэг байна. Тэгэхээр хууль батлагдсаны дараа эрх зүйн боловсрол, соён гэгээрүүлэх ажлуудыг сайн хийх шаардлагатай. Тэгээд иргэдтэй холбогдох хуулийн заалтуудын талаар мэдээлэл олгохоос

гадна хууль хэрэгжүүлэхэд төрийн байгууллагууд холбогдох бэлтгэл ажлуудыг бол зайлшгүй хийх шаардлагатай байгаа.

Э.Бат-Амгалан: Учрал гишүүний микрофоныг өгье. Тодруулъя.

Н.Учрал: Гэрлэхийн тулд энэ хүн амын удмын сан тэр угийн бичиг хөтлөлтөд нь суурилад дүгнэлт гаргана гэхээр одоо нөгөө бэлэн биш. Гэрлэх гэж байгаа 2 хүрээд ирдэг, тэгээд ах дүү, амраг садан, хамаатан садныг нь тодорхойлох тийм боломж байхгүй. Тэгэхээр хуульд ийм заалт орчих юм бол бэлэн биш учраас цаашидаа тэгээд өнгө үзэмжээр чи чинь бараг тэрэнтэй эхнэртэйгээ адилхан царайтай байна шүү дээ гэж хэлээд гэрлэлтийг нь бүртгэхгүй байдал бараг үүсэхээр шинэжтэй л нөхцөл байдалд байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм бэлэн биш нэг ийм заалт оруулчихдаг. Хэрэгжихгүй дээрээс нь хүмүүс хэлмэгдүүдэд янз бүр болох вий. Яагаад гэхээр тэр чинь нөгөө архив дээрээсээ мэдээллээ татаад өнөөдрийн өөрсдийнх нь бүртгэлтэй суурилад, тэгээд нэгдсэн системдээ хөтөлж байж л хийхээс өөр ямар ч арга замгүй болохоор наад заалт чинь бэлэн биш байхад орвол нөгөө өнгө үзэмжээр шийдэх юм болно л гэж хэлэх гээд байгаа юм.

Э.Бат-Амгалан: Санал хэлчихлээ. Адьшаа гишүүн асуулт асууя. Адьшаа гишүүний микрофоныг өгье.

Ш.Адьшаа: Засгийн газраас өргөн барьсан Гэр бүлийн тухай хуулийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэх нь зүйтэй гэсэн ийм бодолтой байна. Энэ гэр бүлийн асуудал, хүүхдийн асуудал, гэр бүлийн харилцаатай холбоотой асуудал бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдалтай холбоотой ийм эмзэг чухал асуудал байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар тодорхой шинэ зүйлийг оруулж ирсэн. Энэ цаг үетэйгээ

зохицсон ийм зохицуулалт хийхийг бас олон талаас нь эрмэлзсэн ийм хууль болсон байна гэсэн ийм бодолтой байна. Ингээд хууль санаачлагчаас 2, 3 зүйлийг тодруулах ийм саналтай байна. Энэ хуульд гэр бүлээ цуцлуулсны дараа хүүхдийн асуудал, түүнчлэн хүүхдэд тэтгэмж өгдөггүй иргэдийн асуудлыг ямар байдлаар зохицуулсан бэ. Ялангуяа энэ үүрэг хариуцлагыг биелүүлэх талаар ямар шинэ зохицуулалтыг оруулж ирж байна. Энэ бол өнөөдөр бас манай нийгэмд байгаа олон том эмзэг асуудлуудын нэг. Гэр бүл салалтын улмаас хүүхэд өнчирдөг. Тэр хүүхдийн хүмүүжил, амьдралын орчин, өсөлт гээд л олон зүйл дээр эцэг эхчүүд бол үүрэг хариуцлагаа биелүүлдэггүй. Тэр шүүхээр гаргасан шийдвэрийн дагуу тэтгэмжээ төлбөрөө төлдөггүй, зайлсхийдэг. Нэн ялангуяа төрд алба хашиж байгаа ч хүмүүст ийм асуудал байдаг шүү дээ. Энэ дээр ер нь ямар асуудал байна вэ гэдэг нэг ийм ойлголт байна.

Энд нэг эрүүгийн хариуцлага хүлээлгэх ийм асуудлуудыг оруулж ирсэн байна. Энэ ямар зүйл дээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх юм гэдгийг тодорхой бас ярих шаардлагатай байна. Дээр нь энэ гадаад улсын иргэдэд хүүхэд үрчлүүлэх асуудлыг бас энэ хуулиар хөндөж оруулж ирсэн. Гадаад улсын иргэдэд хүүхдээ үрчлүүлэх асуудал энэ хуулиар зохицуулдаг юм байна. Тэр цаашид гарах үр дагаврын тухай энд ямар зохицуулалт оруулах вэ. Ямар бодлого байна. Бид бол энэ олон асуудлыг өнөөдөр яриад л байгаа шүү дээ. Монгол Улс ч ийм асуудал Монгол иргэний тухай ч байдаг юм шиг байгаа юм. Ялангуяа энэ гадаад орнуудад ингээд л тэр хүүхэд үрчлүүлээд, тэр хүүхдийг үрчлэх хугацаанд ямар үр дагавар хүлээж байгаа юм. Энэ хүүхдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн өсөх орчин, аливаа хүний үйлдлийн эсрэг ийм үйл ажиллагаанд оролцох дуулахгүй байх ямар баталгааг авч энэ гадаад улсын иргэдэд энэ хүүхэд үрчлүүлэх асуудлыг энэ хуулиар зохицуулах вэ. Энэ хуулиараа энийг

тодорхой болгох шаардлагатай байгаа. Сүүлийн үед хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр бид яриад байгаа шүү дээ. Оросын иргэнийг Америкийн иргэн Оросын иргэний хүүхдийг үрчилж аваад ийм байдалд ингээж.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэмэлт 1 минут өгье.

Ш.Адьяа: Нэмэлт 1 минут авчихъя. Тэгэхээр гадаад улсын иргэнд энэ хүүхэд үрчлүүлснийх дараах үр дагавар гэдэг юм хамгийн их чухал байгаа. Энийг энэ хуулиар бид зайлшгүй зохицуулах ёстой. Хүний наймаа ч гэдэг асуудал байгаа. Түүнчлэн тэр хүүхдийн эрүүл мэнд, өсөх орчин ийм юмнуудыг үр дагаврыг нь тодорхой болгож байж Монгол иргэний тухайд, Монгол хүнээ хамгаалах Монгол төрийн үүрэг байх ёстой гэсэн ийм зарчмыг баримталж байгаа. Энэ талаар 1 хариулт авъя.

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг Солонгоо сайд 5 дугаар микрофон.

Б.Солонгоо: Адьяа гишүүний асуултад хариулъя. Тэгээд 1 дүгээр асуудал нь бол хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой асуудал бол маш их хөндөгдөж байгаа. Тэгээд манай иргэдийн зүгээс бас хэлэлцүүлгийн явцад гарч байгаа маш том асуудал бол гэр бүл цуцалсан тохиолдолд хүүхдээсээ тусдаа амьдарч байгаа эцэг эх хүүхдийн тэтгэлэг төлөх хариуцлагын асуудал бол байна. Тэгээд өнөөдөр 52 хувь нь төлөгдөхгүй байна гэсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдээлэл байна. Тэгээд 1 дүгээрт одоо яг хүүхдийн тэтгэлэг дээр гарч байгаа 1 түлгэмдсэн асуудал нь хэмжээний асуудал байгаа. Тэгэхээр өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хууль дээр яг тодорхой үнийн дүн тавьчихсан байдаг. Тэгээд хүүхдийн наснаас хамаараад шүүх үнийн дүн тавихаар тогтоочихсон. Тэгэхлээр 1 дүгээрт бид нар энэ тэтгэлгийн хэмжээг

тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулж, аргачлалын дагуу шүүх тогтоодог байхаар. Тэгэхээр хүүхэд гэр бүл цуцлахаас өмнө ямар орчин нөхцөлд хүмүүжиж, өсөж байсан яг тэр нөхцөл сөргөөр өөрчлөгдөхгүй байхад анхаарч байгаа.

2 дахь асуудал нь бол энэ хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй шүүхийн шийдвэр гарсан ч гэсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэхгүй байгаа асуудлууд бол байна. Тэгээд үндсэн шалтгаанууд нь бол тодорхой 1 дүгээрт тэтгэлэг төлөгч маань тодорхой эрхэлсэн ажилгүй байдаг, байнгын орлогогүй байдаг, хөдөлмөр эрхэлдэггүй, эс үгүй бол бүртгэлтэй оршин суугаа хаяг дээрээ байдаггүй эрэн сурвалжлагдаж байгаа гэх мэтчилэн үндсэн шалтгаанууд бол байдаг. Тэгэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дагаж нэмэлт, өөрчлөлтийн төсөл бол явж байгаа. Тэгээд энэ үндсэн асуудал маань шийдвэр гүйцэтгэгч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан тодорхой арга хэмжээнүүдийг авсан боловч бас төлбөр төлөгч маань хөрөнгө, орлогогүй, хөдөлмөр эрхлэх боломжтой боловч хөдөлмөр эрхэлдэггүй болох нь тогтоогдсон бол төлбөр төлөгчийн мэдээллийг харьяалах хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шилжүүлж, хөдөлмөр эрхлэхэд бзуучлахад дэмжлэг үзүүлж хамтарч ажиллахаар бас тодорхой асуудлыг тусгасан. Ингэснээрээ цаашидаа тэтгэлэг төлөгч маань байнгын орлоготой болж, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахад төрийн байгууллагууд хамтарч ажиллах шаардлагатай юм гэж харж байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалт бол байхгүй байгаа. Тэгээд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулж дагаж бусад

хуулиуд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа төсөлд бол Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бол санал төсөл байхгүй. Харин Зөрчлийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал байгаа. Энэ нь бас гэр бүл цуцалсан тохиолдолд хүүхдийг асрамждаа авсан эцэг эсвэл эх хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг эсвэл эхийг хүүхэдтэй уулзуулахгүй удаа дараа саад учруулж байгаа бол зөрчлийн хуулиар хариуцлага хүлээдэг байх зохицуулалтыг шинээр оруулсан. Энэ бас шүүхийн практикт бас их тулгамдаж байгаа асуудал болж байгаа. Тэгэхээр тодорхой хариуцлагыг ноогдуулж байж хүүхэд тусдаа амьдарч байгаа эцэг эхтэйгээ байнгын харилцаатай байх хүүхдийн үндсэн эрх хангагдах бас нөхцөлийг бол бүрдүүлнэ гэж үзэж байна.

Хүүхэд үрчлэх асуудал өнөөдөр бас хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 1999 оны Гэр бүлийн тухай хууль дээр бол төрийн захиргааны шийдвэрээр, захиргааны байгууллагын шийдвэрээр гадаад улсын иргэн болон Монгол Улсын иргэнд хүүхэд үрчлэх асуудлыг тусдаа зохицуулалт явж байгаа. Үүнтэй холбогдуулаад бас хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхэд тодорхой гэмт хэргийн хохирогч болох эрсдэлүүд байдаг. Тэгэхээр үүнтэй холбогдуулаад Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр хүүхэд үрчлэх асуудлыг зөвхөн шүүх байгууллага шийддэг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Гэр бүлийн тухай хууль орж ирж байна. Нэгд. Яагаад гэр бүлийн тухай хууль маань ингэж удаж орж ирж байна вэ. Миний мэдэхийн бараг аль ноднин л хаврын, намрын чуулганаар орж ирнэ гээд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд байсан. Тэгээд өнөөдөр ингээд орж ирж байна. Орж ирж байгаа нь сайн байна. 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуулиас

хойш 8 удаа өөрчлөлт орж байсан юм байна. 8 удаа өөрчлөлт ороход өөрчлөлт нь голцуу тэгээд өөр хуулиудыг дагаж шинэчлэгдсэн хуулиудыг дагаж өөрчлөлтүүд орж байсан л ийм л юм байна. Тэгэхээр юу хэлэх гэж байна вэ гэхээр 1999 онд батлагдаж байсан Гэр бүлийн хууль. 1999 оноос хойш өнөөдөр ингээд бараг 20 гаруй жил. Энэ хугацаанд Монгол гэр бүл, Монгол гэр бүлийн гишүүдийн энэ бүтцэд асар том өөрчлөлт гарчээ. Гэр бүлийн гишүүдийн эдлэх ёстой эрх, гэр бүлийн гишүүдийн хүлээх үүрэг, хариуцлага энд асар том өөрчлөлт оржээ. Мөн гэр бүлийн гишүүдийн хооронд асар том харилцааны өөрчлөлт гарчээ. Гишүүдийн хоорондын харилцаанд. Тийм учраас энэ асуудлуудыг гэр бүл гэрлэлт цуцлах, үрчлэлт тэгээд эцэг эхийн үүрэг, хариуцлага бүх асуудлуудыг өнөөдөр энэ шинэчилсэн хуулиар оруулж ирж байгаа нь сайн байна. Энийг бас тодорхой хэмжээнд зохицуулахаар оруулж ирж байгаа нь сайн байна гэж нэгд хэлж хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаагаа хэлье.

2-т би түрүүн Учрал сайдын хэлж байгаатай адилхан санал хэлмээр байна. Нээрээ үнэхээр л хүн амын удмын сан бол үндэсний аюулгүй байдлын хэмжээний асуудал. Өнөөдөр мянга хүрэхгүй хүн амтай сум Улаанбаатар хотоос алслагдсан алс хязгаар аймгийн хөдөө тэр багт сумд үгүй ээ, энэ асуудал үнэхээр тулгамдчихсан асуудал болчихсон байна шүү дээ. Ураг төрлөөрөө суучихсан, цус ойртчихсон. Энэ чинь бодит байдал болчихоод байна. Тэгээд энэ асуудлыг хэрхэн яаж шийдэх вэ гэхээр хэрэгждэггүй нэг удмын сан, угийн бичих хөтлөх гэдэг нэг ийм. Тэгээд хуулиараа орон нутгийн удирдлагуудад үүрэг өгчихсөн. Энэ нь бодит байдал дээр ажил болдоггүй л ийм л юм яваа. Өөр энэ удмын сан Монгол хүний удмын санг хамгаалах үндэсний аюулгүй байдлын хэмжээний асуудлыг шийдэх хэмжээнд ерөөсөө олигтой дорвитой хөшүүрэг хуулийн зохицуулалт алга байна. Тэгээд

та бүхэн ингээд гэр бүлийн садан төрлийн хүмүүсийг хоорондын гэрэлтийг хориглоно гэхчхэн байна шүү дээ. Яаж мэдэх юм. Яаж тогтоох юм. Ингээд суучихсан байвал тэгээд хэн ямар арга хэмжээ авах юм. Энэ хуулиар чинь хэн, ямар арга хэмжээ авах юм. Энийг нэг тодорхой болгож өгөөч.

Гэр бүлийн хамтран амьдрагч албан ёсны гэр бүл 2-ын хоорондын ялгаа зааг нь юу юм бэ. Хамтран амьдрагч. Гэр бүлийн албан ёсны гэр бүлийн эцэг эхүүдийн үүрэг хариуцлагаас хамтран амьдрагчийн гэр бүлийн эцэг эхчүүдийн үүрэг хариуцлага ямар ялгаатай юм. Ингээд 20, 30 насандаа амьдралынхаа ханийг алдчихсан асуудлууд зөндөө байна. 40, 50 насандаа хүнтэй суучихсан, амьдраад явж байгаа асуудлууд зөндөө байна. Энэ бол хамтран юм. Зарим нэг нь гэр бүлээ батлуулдаг. Зарим нэг нь ихэнх нь батлуулдаггүй явдаг. Аяга цайгаа хувааж уух гэж. Тэгвэл тэр батлуулаагүй хамтран амьдрагч гэр бүлийн эцэг эхийнх нь үүрэг нөгөө хүүхдүүд нь хэрхэн яаж тусах юм. Яг гэр бүлийн гэрлэлтийн хуулийнхаа дагуу гэр бүлээ баталгаажуулаад явж байгаа эцэг эхчүүдээс хүлээх үүрэг хариуцлага нь адилхан байх уу. Хамтран амьдрагчийнх арай өөр ялгаатай байх уу. Тэгвэл бас тэр эцэг эх үүргээ биелүүлэхгүй байгаа хамтран амьдрагчийн үүрэг нь.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Минут нэмж авах уу. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Миний асуултыг ойлгочихсон байх гэж бодож байна.

3 дахь асуулт. Гэр бүл гэхээр бид нар эрэгтэй эмэгтэй 2 хүн л хамтран амьдрахыг хэлээд ойлгоод байх юм. Энэ олон улс чинь бас чиг хандлага нь өөр болчихсон байна. 2 эрэгтэй хүний гэр бүлийг яах юм. 2 эмэгтэй хүний гэр бүлийг яах юм гэдэг асуудлууд байна шүү дээ. Энэ манай хуулиар чинь

зохицуулагдаж байгаа юм уу, зохицуулагдахгүй байгаа юм уу. Энийг нэг тодруулъя.

Төрийн байгууллагуудын үүрэг, чиг үүргийг бас хуульчилж зохицуулах гэж орж ирсэн байна. Цэцэрлэг, сургуулийн байгууллагууд, орон нутгийн төр захиргааны байгууллагууд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудын чиг үүргийг яаж оруулж ирж байгаа юм ч байгаа. Гэхдээ одоо байгаагаасаа яаж өөрчилж, шинэчилж, сайжруулж оруулж ирж байгаа юм. Энэ чиг үүргээ хангалтгүй биелүүлбэл ямар хариуцлагын арга хэмжээ байх юм. Энэ чиглэлээр энэ хуулийн төсөлд хэрхэн яаж тусгасан бэ гэдгийг та бүхэн тодруулж өгөөч. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс Солонгоо сайд 5 дугаар микрофон.

Б.Солонгоо: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Тэгээд өнөөдөр бас хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуульд төрөл садангийн хүмүүс хоорондоо гэрлэхийг хориглосон байдаг. Тэгэхээр гэр бүл болоход харшлах шалтгаан бол одоо ч гэсэн өнөөдрийн хуульд мөрдөгдөж байгаа. Бидний хувьд бол Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ДНК-ийн шинжилгээ хийлгэдэг болох зохицуулалтуудыг бол нэмсэн. Ингэснээрээ бас гэрлэгчдийн хэн нэг нь эс үгүй бол сонирхогч тал ДНК-ийн шинжилгээнд хамруулах энэ асуудлыг бас гаргах боломж нээгдэж байгаа. Өөр нэг томоохон асуудал маань яг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусаж байгаа асуудал маань хамтран амьдрагчдын асуудал байгаа. Тэгэхдээ хамтран амьдрагчдын асуудлыг бид нар Гэр бүлийн тухай хууль зохицуулахдаа энийг тодорхой хүчин зүйлүүдийг харгалзаж үзээд хамтран амьдрагчдыг гэрлэлттэй адилхан харилцаатай байсан эсэхийг шүүх тогтоодог болохоор зохицуулалт тусгасан. Тэгэхээр хамтдаа амьдраад тодорхой хугацаа өнгөрсөн

хамтын амьдралаас хүүхэд төрсөн, дундын эд хөрөнгөтэй болсон тохиолдолд гарч байгаа үр дагаврыг ялангуяа хүүхдийн өмнө хүлээх хариуцлагыг гэрлэлт бүртгүүлээгүй байсан ч гэсэн гэрлэлтээ бүртгүүлсэн эцэг эхтэй адилхан үүрэг хариуцлагыг энэ хамтран амьдрагсад маань хүүхдийн өмнө хүлээх зохицуулалтыг оруулсан. Мөн шүүхээс хэрвээ хамтран амьдрахаа болиод хоорондоо дундын эд хөрөнгөтэй холбоотой маргаантай байх юм бол тодорхой шалгуур хангасны үндэс дээр шүүх гэрлэлттэй адилтгаж үзэх харилцаа бол мөн үү, биш үү гэдгийг шүүх тодорхойлохоор тусгасан байгаа. Үндсэн зорилго нь юу вэ гэхээр бид нар гэрлэгчид залуу иргэдээ аль болох гэрлэлтээ бүртгүүлж гэр бүл албан ёсоор бүртгүүлсний үндсэн дээр гэр бүлээ зохиох хандлагыг илүү урамшуулах зорилготой. Хамтран амьдрагчид хамтран амьдрах явцдаа тодорхой бас эрхийг эдлэхгүй байхаар зохицуулалт тусгасан. Тухайлбал өв залгамжлах эрх бол нээгдэхгүй.

2 дахь асуудал нь тэжээн тэтгэх эрх, үүрэг үүсэхгүй байхаар зохицуулсан. Ингэснээрээ залуу гэр бүлүүд маань аль болох гэрлэлтээ бүртгүүлж бид нар бол аль болох албан ёсны гэрлэх гэрлэлтийг аль болох хөхиүлэн дэмжих зорилгоор хамтран амьдрагчдынх нь асуудлыг зохицуулсан. Нөгөө талаасаа дэлхий нийтийн чиг хандлага жишгийн дагуу ч гэсэн гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлэхгүйгээр хамтран амьдарч байгаа тохиолдолд хүүхдийн эрх ашиг хөндөгдөөд байна гэдэг асуудал маш их тулгамдаж байгаа. Тэгэхлээр бас хүүхэд хамтын амьдралаас төрсөн тохиолдолд хүүхдийг гэрлэлт бүртгүүлсэн эсэхээс үл хамаараад эцэг эх адилхан хариуцлага хүлээдэг, хамтын хариуцлага, үүрэг хүлээдэг байх зохицуулалтыг бол тусгасан байгаа. Цаашидаа мэдээж бол бидний хувьд бол анхаарах асуудлууд маань Гэр бүлийн хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын чиг үүрэг орхигдохгүй байх салбар хооронд

тодорхой асуудал орхигдохгүй, хийдэл гарахгүй байх дээр анхаарч ер нь төрийн байгууллагуудын чиг үүрэгтэй холбоотой тусгайлсан бүлгийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэмсэн.

Ингэснээрээ бас цаашидаа Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд ялангуяа гэр бүлийг тогтвортой байхад чиглэсэн төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын чиг үүрэг тодорхой байхад гэр бүлийн тогтвортой байдалд дөхөм болох юм болов уу гэж харж байна.

Төрийн бус байгууллагууд яг мэргэжлийн байгууллагуудын оролцоотой холбоотой заалт бол байхгүй. Тэгэхдээ төрийн бус байгууллагуудтай, мэргэжлийн байгууллагуудтай, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллах боломж бол нээлттэй байгаа. Тэгэхээр ялангуяа гэр бүлийн.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүн хариулт авч болсон уу. Солонгоо сайдын микрофоныг өгье.

Б.Солонгоо: Баярлалаа. Ерөнхийдөө бол манай Үндсэн хууль дээр гэрлэлтийг тодорхойлчихсон байдаг. Гэрлэлт гэдэг маань эрэгтэй, эмэгтэй 2 хүний хооронд гэсэн харилцааг бол тодорхойлчихсон. Тэгэхээр хэрвээ бид нар ижил хүйстний бусад гэрлэлтийн харилцааг хуулиар хүлээн зөвшөөрнө гэвэл 1 дүгээрт Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага бол үүснэ. Тэгэхээр бид нар Үндсэн хуулиудынхаа заалтыг дагаад яг гэрлэлт маань эрэгтэй, эмэгтэй 2-ын хооронд гэдэг зохицуулалт бол Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд байна.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлэх гишүүд

нэрсээ өгнө үү. Үг хэлэх гишүүд алга байна.

Би 2 үг нэмээд хэлчихье. Ер нь бол энэ аягүй чухал хууль орж ирж байна. Би энд ингээд гарсан судалгаануудыг харж байна. Тэгээд энэ дээр нэг сэтгэл зовниулсан асуудал байна. Ер нь ингээд гэр бүлийн асуудлаар маргаан шийдүүлсэн статистикийг Гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн тоо гээд харахад үнэхээр ихэнх нь олон жилийн турш дандаа гэрлэлт цуцлах энэ асуудлууд явж байна. Энэ дээр бас гэрлэлт цуцалж байгаа шалтгаан гэдэг дээр бол ихэнх нь тааламжгүй харьцаа гээд. Энийг бол яг судлах хэрэгтэй. Энэ тааламжгүй харьцаа гэдэг бол ойлгомжтой. Мэдээж тааламжгүй харьцаанаас л байгаа шүү дээ. Тэгэхдээ үүний ард эдийн засгийн үзүүлэлтүүд нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд ер нь хэр нөлөөлж байгаа вэ гэдэг, өөрөөр хэлбэл ажилгүйдэл, тогтвортой ажлын байртай байхгүй байгаа нөхцөл байдал, эдийн засгийн өсөлт удааширч байгаатай холбоотой энэ юмнууд хэр нөлөөлж байна. Олон Монгол залуучууд гадагшаа гарч ажиллаад байна. Ингэхээр өөрийн эрхгүй тусдаа амьдраад эхлэхлээрээ энэ статистик үзүүлэлтүүдэд бол нөлөөлөөд байгаа байх.

Энэ хууль оруулж ирж байгаагийн нэг чухал юм нь юу гэхээр энэ хамтран амьдарч байгаа хүмүүсийн тоо нээрээ бас нэлээн олон болчихсон байгаа. Энийг бол эрх зүйн хувьд бол зохицуулж өгөх нь нэн чухал байгаа. Тэгэхээр шинэ шинэ энэ олон зүйлс гарч ирсэнтэй холбогдолтой Гэр бүлийн хуулийг оруулж ирж байгаа нь бол их чухал байна. Зөв байна гэж хэлмээр байна. Түрүүн Адъяаа гишүүн их чухал юм ярьж байсан. Энэ хүүхэдтэй болчхоод хүүхдийнхээ тэтгэмжийг төлөхгүй байгаа 2-ын хооронд эрчүүд байна. Энэ дээр үнэхээр Монгол эрчүүдэд байхааргүй зан чанар байхгүй юу. Энэ дээр бол зөвхөн эдийн засгийн хөшүүргээр биш нийгэм өөрөө өөрийнхөө тэр манай

нийгэмд байж байгаа соёлын үнэт зүйл чинь өөрөө бас маш хүчтэй механизм байхгүй юу. Энийгээ нэлээн ашиглах хэрэгтэй. Шашинд суурилсан манай бас ахиад энэ суурь үнэт зүйлүүд байгаа. Энийгээ бас гүйцэд ашиглах энэ боломжуудаа авч үзэх хэрэгтэй, харгалзах хэрэгтэй. Энэ чинь харагдахгүй боловч маш хүчтэй механизмууд шүү. Энийгээ бид нар дутуу үнэлж болохгүй. Энийгээ тэгэхээр гүйцэд ашиглах тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Ингээд гишүүд маань ороод ирчихсэн байгаа учраас хэлэлцэх эсэх асуудлаар хэлэлцэхийг дэмжье ээ гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ингээд 76 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Гэр бүлийн хуулийн гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

17.03 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ